



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ГЭРЭЭЛЭГЧ НЬ ГАЗРЫН ТОСТОЙ ХОЛБОГДСОН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАМААРАХ АЖИЛ ГҮЙЛГЭЭГ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ИЖ БҮРЭН, ҮНЭН ЗӨВ ТУСГАЖ ТАЙЛАГНААГҮЙ, АМГТГ ХЯНАЖ, ШАЛГАЖ ДҮГНЭЭГҮЙ НЬ БХГ, ГАЗРЫН ТОСНЫ БОЛОН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ХУУЛЬ, БҮРТГЭЛИЙН СТАНДАРТЫГ ЗӨРЧСӨН ТУЛ БАТАЛГААЖУУЛАХ БОЛОМЖГҮЙ БАЙНА

АУДИТЫН СЭДЭВ: ГАЗРЫН ТОСНЫ САЛБАРТ БХГ-ЭЭР ОЛБОРЛОЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ГЭРЭЭЛЭГЧИЙН НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ӨРТӨГ НӨХӨГДСӨН БОЛОН НӨХӨГДӨХ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ, ГАЗРЫН ТОСНЫ ЭКСПОРТ, БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН ТООЦОО, ХУВААРИЛАЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТАД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН
АУДИТЫН КОД: СНАГ-2023/11-НА-НА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.



Улаанбаатар хот
2023 он

**МУЕА-ын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Ц.Наранчимэг**

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

**Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын
газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням**

Утас: 263755 Цахим хаяг: sambuunyamy@audit.gov.mn

Аудитын менежер Д.Отгонбаяр

Утас: 261729 Цахим хаяг: otgonbayard@audit.gov.mn

Ахлах аудитор Д.Жаргалсайхан

Утас: 261729 Цахим хаяг: jargalsaikhand@audit.gov.mn

Ахлах аудитор Л.Нямтөмөр

Утас: 261729 Цахим хаяг: nyamtumurl@audit.gov.mn

Аудитор Ц.Батсүх

Утас: 261729 Цахим хаяг: batsukhts@audit.gov.mn



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2023 оны 12 сарын 26 өдөр

Дугаар А/168

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт, 29.3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт”-д хийсэн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар өгсөн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2.Аудитын тайланг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороод, Монгол Улсын Ерөнхий сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газарт тус тус хүргүүлэхийг Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Наранчимэг)-д үүрэг болгосугай.


3.Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд (Л.Оюун-Эрдэнэ), Уул уурхай хүнд үйлдвэрийн сайд (Ж.Ганбаатар), Ашигт малтмал, газрын тосны газрын дарга (Л.Баярмандал) нарт зөвлөсүгэй.

4.Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газар (Я.Самбууням)-т даалгасугай.

5.Аудитын тайланг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодоор хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж, танилцуулга хийхийг Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Наранчимэг)-д даалгасугай.

6.Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг Санхүү-Нийцлийн аудитын газрын аудитын менежер (Д.Отгонбаяр)-т үүрэг болгосугай.

Д.ЗАНДАНБАТ



АЛБАН ШААРДЛАГЫН ЖАГСААЛТ

№	Дугаар, огноо	Зөрчлийн утга	Хэрэгжүүлэх арга хэмжээ
1	2023.12.15 №1134/АО170050 СНАГ-2023/11- НА-НА	<ol style="list-style-type: none"> Бүтээгдэхүүн хуваах гэрээний 4 дүгээр зүйлд зөвхөн үр ашигтай нээлт хийсэн нөхцөлд гэрээлэгч өртөг зардлыг нөхөж авахаар заасан боловч Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайд үр ашигтай нээлт илрүүлсэн баримт мэдээлэл байхгүй, Засгийн газрын төлөөлөгчид мэдэгдсэн эсэх нь тодорхойгүй байхад 1996-2018 оны хугацаанд 1,181.9 сая ам.долларын өртөг зардлыг нөхөн авч, 2,100.4 сая ам.долларын өртөг зардлыг нөхөж авахаар хуримтлуулан тооцсон байна. Гэрээний талууд хайгуулын хугацааг хэрхэн сунгасан, олборлолтод хэзээ шилжсэн талаарх үндэслэлтэй тайлбар, тодруулга, нотлох баримтыг гаргаж чадахгүй байна. Тосон Уул XIX талбайд Өртөг нөхөгдөх зардлыг анх нөхөж авсан 1996 оноос тооцвол 2016 онд анхны үр ашигтай цооногийн хугацаа дуусаж, үр ашигтай нээлт бүртгэгдэх сүүлийн хугацаагаар тооцвол 2023 оны 4 дүгээр сард Тосон Уул XIX талбайн Бүтээгдэхүүн хуваах гэрээний хугацаа бүрэн дууссан байна. Гэрээний талууд БХГ-ээр тогтоосон хайгуулын хугацааг хэрхэн сунгасан, үр ашигтай нээлтийг хэзээ бүртгүүлсэн талаарх мэдээ, тайлан, тайлбар, тодруулга нь тодорхойгүй, нотлох баримтаар хангагдахгүй байна. Австралийн Комманд Петролеум компаниар толгойлуулсан олон улсын газрын тосны консорциум нь "СОКО Монгол Инк"-д эрхээ шилжүүлсэн тухай болон Соко Тамсаг Монгол ХХК-иас Дачин Ойлфилд Лимитед компанид эрх шилжүүлсэн тохиролцоо нь БХГ-ний 24 дүгээр зүйлд эрх шилжүүлэлтийг МУЗГ-ын бичгээр өгсөн зөвшөөрлийн дагуу олгохоор заасныг зөрчиж байна. Ашигт малтмал, газрын тосны газар /хуучнаар Газрын тосны хэрэг эрхлэх газар/ хуулиар олгогдоогүй эрх эдэлж гэрээлэгчтэй 2004 онд нэмэлт хэлэлцээр хайгуулын хугацааг 5 хүртэл жилээр сунгахаар тохиролцсон нь бүтээгдэхүүн хуваах гэрээтэй нийцэхгүй байна. Мөн гэрээлэгч, Ашигт малтмал, газрын тосны газар /хуучнаар Газрын тосны хэрэг эрхлэх газар/ хооронд 2004 онд байгуулсан түүхий тос тээвэрлэх, борлуулах тухай протоколоор 	<ol style="list-style-type: none"> БХГ-г үндэслэн үр ашигтай нээлт гэж тооцсон цооног тус бүрийн хугацааг нарийвчлан тогтоож бүртгэлжүүлэх; Тосон Уул XIX талбайн Бүтээгдэхүүн хуваах гэрээний хугацаа дууссан тул уг талбайгаас олборлосон газрын тосны экспортлох үйл ажиллагааг зогсоох; Газрын тосны үйл ажиллагааны явцад гэрээлэгч хариуцах зардлыг үр ашигтай нээлт гэж нөхөж авахаар буруу тооцон 2018 оны жилийн эцсийн байдлаар хуримтлуулсан 2,100.4 сая ам.долларын өртөг зардлыг МУЗГ Бүтээгдэхүүн хуваах нөхцөлөөр нөхөж төлөхгүй байхаар аудитаар баталгаажуулж байгааг гэрээлэгчид мэдэгдэж тооцоо нийлэх; Эрх шилжүүлсэн тохиролцоо, хугацаа сунгасан хэлэлцээр, борлуулалтын зардлыг Монголын талаас эргүүлэн авахаар тохирсон протоколууд нь БХГ-ний адил хүчин төгөлдөр эрх зүйн баримт бичиг болохыг тодорхой болгох; Тохиролцоо, хэлэлцээр, протокол зэрэг БХГ зөрчсөн эрх зүйн баримт бичгийг мөрдөхгүй байх; Цаашид зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Ашигт малтмал, газрын тосны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Л.Баярмандал/-д даалгав.

		борлуулалтын зардлыг Монголын талаас эргүүлэн авахаар тохирсон нь БХГ-тэй нийцээгүй, уг хэлэлцээр нь хүчин төгөлдөр эрх зүйн баримт бичиг болох нь тодорхойгүй байна.	
2	2023.12.15 №1135/АО170050 СНАГ-2023/11- НА-НА	Газрын тосны чиглэлээр 2005 оноос хойш үйл ажиллагаа эрхэлж байгаа “Петрочайна Дачин Тамсаг” ХХК нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг мөрдөхгүй, үндсэн үйл ажиллагаатай холбоотой ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд иж бүрэн тусгаагүй байхад Сангийн яам нь холбогдох хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	1.Газрын тосны салбарт олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагад санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг мөрдүүлэх, харилцагч санхүүгийн байгууллагатай хамтран хяналтыг хэрэгжүүлж байх, биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх; 2. Цаашид зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байхыг Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Ж.Ганбат/-д даалгав.
3	2023.12.26 №1134/АО170050 СНАГ-2023/11- НА-НА	1. Ашигт малтмал, газрын тосны газар нь гэрээлэгчээс ирүүлсэн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтыг анхан шатны баримтад үндэслэн санхүүгийн тайланд тусгасан эсэхийг хянаж хүлээж аваагүй, үнэн зөв дүгнэлт тайланг Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй. 2. ҮАГ-аас буюу өмнөх аудитаар илрүүлсэн зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх 3 албан шаардлага, 5 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.	Ашигт малтмал, газрын тосны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Баярмандалд Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд /Ж.Ганбаатар/-д даалгав.

Агуулга

Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгийн жагсаалт.....	2
Үндэсний аудитын газар:	Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	3
	Аудитын зорилго, зорилт	3
	Аудитын хамрах хүрээ.....	3
<i>МУЕА-ын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг</i>	Үндсэн мэдээлэл	3
	Аудитын арга зүй.....	4
<i>Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням</i>	БҮЛЭГ 1. ГАЗРЫН ТОСНЫ НИЙТ ОРЛОГО 8.4 ИХ НАЯД, НИЙТ ЗАРДАЛ 11.4 ИХ НАЯД, АЛДАГДАЛ 3.0 ИХ НАЯД ТӨГРӨГ БАЙХАД ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ХУВЬД ҮР АШИГТАЙ ГЭЖ ҮЗЭН ӨРТӨГ ЗАРДЛЫГ НӨХӨЖ АВСАН НЬ БХГ-Г ЗӨРЧИЖ БАЙНА	6
	1.1. Төсөл нь эдийн засгийн хувьд үр ашиггүй байхад гэрээлэгч өртөг зардал нөхөж авсан нь БХГ-ний заалттай нийцэхгүй байна	6
<i>Санхүү-Нийцлийн аудитын газрын Аудитын менежер Д.Отгонбаяр</i>	1.2. Тосон Уул XIX талбайн ӨНЗ-ыг 1996 оноос нөхөж авснаар үр ашигтай нээлт бүртгэгдсэн гэж тооцвол БХГ-ний хүчин төгөлдөр хугацаа дууссан байна	10
<i>Ахлах аудитор Д.Жаргалсайхан Л.Нямтөмөр</i>	1.3.“Петрочайна Дачин Тамсаг” ХХК газрын тостой холбогдсон бүх үйл ажиллагаанд хамаарах ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд иж бүрэн, үнэн зөв тайлагнаагүй, түүнийг хянах байгууллагууд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй байна	12
<i>Аудитор Ц.Батсүх</i>	БҮЛЭГ 2. ГЭРЭЭЛЭГЧИЙН БАТЛАГДСАН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨСӨВ, ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ГАЗРЫН ТОСНЫ ЭКСПОРТ, БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО ЗӨРҮҮТЭЙ БАЙХАД АМГТГ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ДҮГНЭЛТ ТАЙЛАНДАА ТУСГААГҮЙ БАЙНА	14
<i>“Ди Эй Би Жи- Аудит” ХХК</i>	2.1. АМГТГ-ын дүгнэлт, тайлан хуулийн шаардлага хангахгүй байна	14
2023 оны 12 дугаар сар	2.2. Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр зохицуулаагүй байхад газрын тос борлуулахтай холбоотой гарсан зардлыг суутгасны дараа хуваах тосыг тооцсон байна	17
Тайланг ҮАГ-ын цахим сайтаас үзнэ үү. www.audit.mn	2.3. АМГТГ нь өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, тогтоосон төлбөрийн актыг биелүүлэх талаар үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүйгээс хэрэгжилт хангалтгүй байна	22
<i>Аудитын тайлан дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261885, 261740 дугаарын утсаар харилцана уу.</i>	Шалгагдагч, аудитад хамрагдагч байгууллагуудын санал	26
	Дүгнэлт	41
	Зөвлөмж	42
	Хавсралт 1	43
	Хавсралт 2	44
	Хавсралт 3	45
	Хавсралт 4	46
	Хавсралт 5	47
Хаяг:	Албан шаардлага	50
<i>Үндэсний аудитын газар</i>		
<i>Чингэлтэй дүүрэг,</i>		
<i>Бага тойруу-3</i>		
<i>Засгийн газрын</i>		
<i>ІҮ байр</i>		
<i>Улаанбаатар хот</i>		
<i>15160</i>		
<i>Монгол Улс</i>		

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар
БХГ	Бүтээгдэхүүн хуваах гэрээ
ГТНАТ	Газрын тосны нөөц ашигласны төлбөр (роялти)
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
НА	Нийцлийн аудит
СНАГ	Санхүү-нийцлийн аудитын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
УУХҮС	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд
ӨНЗ	Өртөг нөхөгдөх зардал

ХҮСНЭГТ, ГРАФИК, ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1	АМГТГ-аас дүгнэлт, тайлан ирүүлсэн хугацаа
Хүснэгт 2	Тосон уул XIX, Тамсаг XXI талбайгаас 1997-2022 оны улсын төсөвт төвлөрүүлсэн газрын тосны орлого
Хүснэгт 3	Өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын дүн
Хүснэгт 4	“Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн 2019-2022 оны тайлагнасан ӨНЗ-ын дүн
Зураг 1	Орлого, зарлагын зөрүү
Зураг 2	Тосон Уул XIX талбайн хугацаа
График 1	Аудитлагдсан санхүүгийн тайлангийн зардлын дүнг ӨНЗ-ын дүнгийн харьцуулалт
Хүснэгт 5	АМГТГ-аас ирүүлсэн дүгнэлт, тайлан үзүүлэлт
Хүснэгт 6	Газрын тосны экспорт
Хүснэгт 7	Борлуулалтын орлого
Хүснэгт 8	Газрын тос борлуулахтай холбоотой гарсан зардал
Хүснэгт 9	Тээврийн зардал /2019-2021 он/
Хүснэгт 10	Өртөг нөхөгдөх зардал /2019-2021/
Хүснэгт 11	АМГТГ-ын хяналт, шалгалтаар гэрээлэгчийн 2019-2021 оны өртөг нөхөгдөх зардлын хэмжээ
Хүснэгт 12	АМГТГ-ын хянаж шалгасан Гэрээлэгчийн 2020 оны өртөг нөхөгдөх зардлын хэмжээ
Хүснэгт 13	Гэрээлэгчийн тайлагнасан, АМГТГ-ын хянаж дүгнэсэн борлуулалтын орлогын хуваарилалтын тооцоо
Хүснэгт 14	Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, төлбөрийн актын хэрэгжилт

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3¹-т заасан бүрэн эрхийн хүрээнд Газрын тосны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2², 37 дугаар зүйлийн 37.2³, 37.3⁴ дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2022 оны 09 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/04 дүгээр тушаалаар баталсан аудитын жилийн төлөвлөгөөг үндэслэн гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

Газрын тосны салбарт БХГ-ээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн бүртгэж тайлагнасан нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалт, санхүүгийн тайлан нь холбогдох хууль тогтоомж, БХГ-тэй нийцэж буй эсэхийг хянан баталгаажуулж, аудитын тайланг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэлээ.

Аудитын хамрах хүрээ

Аудитаар дараах тайлан, ажлын баримт, үйл ажиллагааг хамруулсан. Үүнд:

- АМГТГ-аас баталсан гэрээлэгчийн газрын тосны олборлолтын үйл ажиллагааны тухайн жилийн ажлын төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, ажлын тайлан, өдөр тутмын мэдээ, сар, улирал, жилийн нэгтгэл, анхан шатны баримт, материал;
- Нийт хөрөнгө оруулалт, ӨНЗ-ын тайлан /өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ/, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтын тооцоо болон санхүүгийн тайлан, холбогдох анхан шатны баримт материал;
- АМГТГ-ын гэрээлэгчээс ирүүлсэн дээрх тайлангуудыг хянан шалгасан дүгнэлт, тайлан, ажлын баримт;
- АМГТГ-аас олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчтэй санхүү, эдийн засгийн харилцаанд оролцсон санхүүгийн баримтууд;
- Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайн талаар байгуулсан БХГ, түүнтэй холбогдон гарсан протоколууд.

Үндсэн мэдээлэл

Монгол Улсад БХГ-ээр газрын тосны олборлолтын үйл ажиллагаа явуулах уул уурхайн эдэлбэр буюу ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан дараах гэрээлэгчид байна. Үүнд:

1. “Петрожайна Дачин Тамсаг” ХХК (Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбай);
2. “Доншен Газрын тос (Монгол)” ХХК (БХГ-97 талбай);
3. “Петроматад” ХХК (Матад ХХ талбай).

¹Төрийн санхүү, төсвийн хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд хуульд заасан болон шаардлагатай тохиолдолд тодорхой асуудлаар аудит хийх;

²Өртөг нөхөгдөх зардлыг төрийн аудитын байгууллагаар баталгаажуулж, бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан өртөгт газрын тосны хувиар нөхнө.

³Энэ хуулийн 37.1-д заасны дагуу төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн тайлан, дүгнэлтэд төрийн аудитын байгууллага аудит хийж, баталгаажуулна.

⁴Төрийн аудитын байгууллага энэ хуулийн 37.2-т заасан аудитыг гүйцэтгэхдээ хараат бус шинжээч, мэргэжилтэн, аудитын хуулийн этгээдийг оролцуулж болно.

Үүнээс Газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д заасны дагуу АМГТГ-аас “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн 2019-2021 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад хяналт шалгалт хийж тайлан, дүгнэлтийг төрийн аудитын байгууллагад ирүүлсэн тул баталгаажуулах аудитыг гүйцэтгэсэн.

Харин АМГТГ-аас “Петроматад” ХХК, “Доншен газрын тос /Монгол/” ХХК-д хийсэн хяналт шалгалтын дүгнэлт, тайланг ирүүлээгүй тул тус компаниудыг аудитад хамруулаагүй болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн /2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр/ Зургаадугаар зүйлийн 2-д “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. ...байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно”, Хорин тавдугаар зүйлийн 7-д “... Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно” гэж Төрийн аудитын байгууллагын үндсэн чиг үүргийг заасан байна.

Төрийн аудитын тухай хууль 2020 онд шинэчлэн батлагдаж, Газрын тосны тухай хуульд АМГТГ-аас хянаж шалгасан дүгнэлт, тайланг Төрийн аудитын байгууллагад ирүүлэхээр өөрчлөн найруулсан байна. Хуулийн зохицуулалтын дагуу АМГТГ-аас дүгнэлт, тайланг дараах байдлаар ирүүлсэн. Үүнд:

Хүснэгт 1. АМГТГ-аас дүгнэлт, тайлан ирүүлсэн хугацаа

№	Дүгнэлт, тайлан	Албан бичгийн огноо	Албан бичгийн дугаар
1	“Петрочайна Дачин тамсаг” ХХК-ийн 2019 оны өртөг нөхөгдөх зардал, борлуулалтын орлогын тооцоо хуваарилалтад хийсэн	2023.06.27	3/3246
2	“Петрочайна Дачин тамсаг” ХХК-ийн 2020 оны өртөг нөхөгдөх зардал, борлуулалтын орлогын тооцоо хуваарилалт	2023.07.31	1/3726
3	“Петрочайна Дачин тамсаг” ХХК-ийн 2021 оны өртөг нөхөгдөх зардал, борлуулалтын орлогын тооцоо хуваарилалт	2023.09.29	1/4658

Аудитын арга зүй

Төрийн аудитын тухай, Газрын тосны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бусад хууль тогтоомжийн холбогдох зүйл, заалтуудыг шалгуур үзүүлэлт болгон АДБОУС 100-400, 4000, 4001 болон МУЕА-ын 2021 оны А/71 дүгээр тушаалаар баталсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”, 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ыг баримтлан аудитыг гүйцэтгэлээ.

Үндэсний аудитын газраас “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-д хийсэн өмнөх аудитаар дараах зөрчлийг илрүүлсэн. Үүнд:

- Газрын тостой холбоотой үйл ажиллагааг санхүүгийн тайланд тусгаагүй, борлуулалтын орлого, өртөг нөхөгдөх зардлын тайлан, анхан шатны баримтыг хятад, англи хэлээр үйлдэж, Газрын тосны тухай болон МУ-ын бусад хууль тогтоомж, БХГ-г мөрдөж ажиллаагүй;
- АМГТГ гэрээлэгчийн батлагдсан төсвийн гүйцэтгэл, тухайн оны хөрөнгө оруулалт, ӨНЗ, нөөц ашигласны төлбөр, олборлосон болон борлуулсан

газрын тосны тайланг хянаж, нэгтгээгүй, хууль тогтоомж болон БХГ-ээр хүлээсэн чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн;

- БХГ-г Газрын тосны тухай хуульд нийцүүлэн шинэчлэх ажил удааширснаас гэрээний зарим зүйл, заалт уг хууль болон бусад хууль тогтоомжтой зөрчилдөх, төрийн байгууллагуудаас хэрэгжүүлсэн хяналт шалгалт үр дүнгүй болж, гэрээний талуудын санал зөрөлдсөнөөс төслийн үр ашиг буурах зэрэг олон үр дагавар үүссэн.

Дээрх зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх 3 албан шаардлага, 30.4 сая ам.долларын 1 төлбөрийн акт, 10 зөвлөмжийг холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлсэн боловч хэрэгжилт хангалтгүй байна.

Иймд дээрх хууль тогтоомжийн үл нийцлийн асуудлыг эрсдэлд авч үзэн, БХГ-ний хэрэгжилт, АМГТГ-аас зохих хяналтаа хэрэгжүүлсэн эсэхэд холбогдох мэргэжилтнүүдээс шаардлагатай баримт, материал, лавлагаа тайлбар авах, гэрээлэгчийн гүйцэтгэлтэй тулгах зэрэг аудитын нарийвчилсан горим, сорилыг хэрэгжүүлэн нотлох зүйл цуглуулж, дүн шинжилгээ хийн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

БҮЛЭГ 1. ГАЗРЫН ТОСНЫ НИЙТ ОРЛОГО 8.4 ИХ НАЯД, НИЙТ ЗАРДАЛ 11.4 ИХ НАЯД, АЛДАГДАЛ 3.0 ИХ НАЯД ТӨГРӨГ БАЙХАД ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ХУВЬД ҮР АШИГТАЙ ГЭЖ ҮЗЭН ӨРТӨГ ЗАРДЛЫГ НӨХӨЖ АВСАН НЬ БХГ-Г ЗӨРЧИЖ БАЙНА

1.1. Төсөл нь эдийн засгийн хувьд үр ашиггүй байхад гэрээлэгч өртөг зардал нөхөж авсан нь БХГ-ний заалттай нийцэхгүй байна

БХГ-нд хөрөнгө оруулагч газрын тостой холбоотой үйл ажиллагааны зардлыг бүрэн хариуцаж, үр ашигтай ажиллах, эрсдэлийг удирдах онцлог зохицуулалттай.

“Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн Тосон уул XIX, Тамсаг XXI гэрээт талбайн талаар байгуулсан БХГ-ний 4 дүгээр зүйлд “Гэрээнд өөрөөр заагаагүй бол газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад шаардагдах бүх өртөг, зардлыг гэрээлэгч хариуцна...”, “...хэрэв газрын тосны үйл ажиллагааны үр дүнд үр ашигтай нээлт хийвэл уг үйл ажиллагаатай холбогдон гарсан өртөг зардлыг гэрээлэгч энэ гэрээний дагуу нөхөж авч болно” гэж заасан байна.

Аудитаар АМГТГ болон холбогдох байгууллагын архивт Тамсаг XXI талбайд 2010 онд өрөмдсөн 72 цооногийг нээлтийн цооноогоор бүртгэснээс өөр Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайд үр ашигтай нээлт хийсэн талаар баримт мэдээлэл байхгүй, гэрээлэгч үр ашигтай нээлтийн талаар МУЗГ-ын төлөөлөгчид мэдэгдсэн эсэх нь нотлогдохгүй байна.

Үүнээс үзэхэд гэрээний талууд үр ашигтай нээлтийг бүртгэх, МУЗГ-ын төлөөлөгчид мэдэгдэх, үнэлэх зэрэг гэрээний заалтыг хэрэгжүүлээгүйгээс гадна БХГ-ний 4 дүгээр зүйлийг зөрчиж, өртөг зардлыг нөхөж авсан байна.

Хуульчийн дүгнэлтээс⁵ “... Хэрэв газрын тостой холбогдсон үйл ажиллагааны үр дүнд үр ашигтай нээлт хийвэл...” гэх хэсэг нь тус нөхцөлийг авч хэрэглэх урьдчилсан нөхцөлийг заасан байна. Урьдчилсан нөхцөл биелсэн тохиолдолд буюу “газрын тостой холбогдсон үйл ажиллагааны үр дүнд ашигтай нээлт хийх юм бол “эрх зүйн үр дагавар”-ын заасан хэсгийн зохицуулалт биелэхээр байна. Үүнийг тодруулбал, ашигтай нээлт хийвэл “үйл ажиллагаатай холбоотой гарсан өртөг зардлыг Гэрээлэгч энэ гэрээний дагуу нөхөн авна”. Эсрэгээр, ашигтай нээлт хийхгүй бол өртөг зардлыг нөхөн авах шаардах эрхийг Гэрээлэгч эдлэхгүй буюу нөхөн авахыг шаардах эрхгүй гэсэн үг.

Энэ нөхцөлийг дүгнэвэл, Иргэний хуулийн 44 дүгээр зүйлд зохицуулагдсан “болзол тавьж хийсэн хэлцэл” гэх хэлцлийн нөхцөлийг хангаж байна гэж үзэх үндэслэлтэй. Иргэний хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-т “Тодорхойгүй байгаа ямар нэгэн үйл явдал болсон нөхцөлд хэлцлийг хэрэгжүүлэх, эсхүл хэлцлийг дуусгавар болгохоор тохиролцож хийсэн хэлцлийг болзол тавьж хийсэн хэлцэл гэнэ” – гэж зохицуулсан. Түүнчлэн, Иргэний хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т заасны дагуу болзол тавьж хийсэн хэлцлийн нэг төрөл нь хойшлуулах болзлоор хийсэн хэлцэл байдаг. Тодруулбал, Иргэний хуулийн 44.2-т хуульчилсны дагуу “бий болох эсэх нь мэдэгдэхгүй, эсхүл нэгэнт бий болсныг нь хэлцэл хийгч талууд мэдээгүй байгаа үйл явдлаас шалтгаалан хэлцэлд заасан эрх үүрэг нь үүсэхээр тохиролцсон бол хойшлуулах болзлоор хийсэн хэлцэл гэнэ”.

Иргэний хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т зохицуулсан хойшлуулах болзлоор хийсэн хэлцлийн тодорхойлолттой Гэрээний 4 дүгээр зүйлийн 2 дахь өгүүлбэрт өгөгдсөн нөхцөлийг харьцуулан дүгнэвэл, “... Хэрэв газрын тостой холбогдсон үйл ажиллагааны үр дүнд үр ашигтай нээлт хийвэл уг ажиллагаатай холбоотой гарсан өртөг зардлыг Гэрээлэгч энэ гэрээний дагуу нөхөн авна...” гэх нөхцөл нь хойшлуулах болзлоор хийсэн хэлцлийн нөхцөл гэж дүгнэх үндэслэлтэй байна. Үүнийг тайлбарлавал, “... үйл ажиллагааны үр дүнд үр ашигтай нээлт хийвэл” – гэх хэсэг нь болзол заасан хэсэг болж байна. Энэ болзол биелсэн тохиолдолд “... уг ажиллагаатай холбоотой гарсан өртөг зардлыг Гэрээлэгч энэ гэрээний дагуу нөхөн авна” – гэх хэсэг нь Гэрээлэгч болзол биелсэн тохиолдолд гарсан өртөг зардлаа өөрт нь нөхөн төлөхийг шаардах эрх эдлэнэ гэсэн үг. Өөрөөр хэлбэл, болзол биелсэн тохиолдолд буюу “үр ашигтай нээлт хийсэн тохиолдолд” Гэрээлэгч өртөг зардлыг өөрт нь нөхөн төлж өгөхийг шаардах эрх нь үүснэ гэсэн үг. Эсрэг

⁵ Хууль зүйн ухааны доктор Б.Тэмүүлэн

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

тохиолдолд шаардах эрх үүсэхгүй. Улмаар, болзол биелсэн тохиолдолд гэрээний 4 дүгээр зүйлд заасан өртөг зардлыг өөрт нь нөхөж төлөхийг шаардах эрх нь үүснэ гэсэн үг.

Түүнчлэн, Иргэний хуулийн 44.2-т хуульчилсны дагуу болзол нь биелэх эсэх нь мэдэгдэхгүй шинжтэй нөхцөл байх шаардлагатай. Ирээдүйд биелэх нь тодорхой буюу гарцаагүй байвал болзлыг Иргэний хуулийн 44.2-т хуульчилсан “хойшлуулах болзол” гэж дүгнэх үндэслэлгүй.

Гэрээний 4 дүгээр зүйлийн нөхцөлүүдийг дүгнэвэл, “үр ашигтай нээлт хийх” гэх болзол нь ирээдүйд биелэх эсэх нь тодорхойгүй болзол болох нь маргаангүй байна.

Гэрээг тайлбарлах системчилсэн тайлбар хийх аргачлалыг энд хэрэглэвэл, Гэрээний 4 дүгээр зүйлийн 2 дахь өгүүлбэрийг дангаар нь биш, харин тус зүйлийн 3 дахь болон 4 дахь өгүүлбэртэй холбон тайлбарлах нь зүйтэй. Ийнхүү системчилсэн тайлбар хийвэл, 4 дүгээр зүйлийн 3 дахь өгүүлбэрт “... Энэ гэрээнд оролцогч аль ч тал ямар нэгэн ийм нээлт хийнэ гэсэн баталгаа гаргахгүй байх бөгөөд хэрэв нээлт хийвэл түүнийг үр ашигтай болно гэсэн баталгаа гаргахгүй” - гэж зохицуулснаас дүгнэвэл, “үр ашигтай нээлт хийх” гэх болзол нь заавал буюу гарцаагүй биелэх нөхцөл биш болох нь тодорхой байна. Учир нь, гэрээний талуудын аль нэг нь нээлт хийнэ гэх баталгаа гаргахгүй гэж байгаа нь гэрээний талууд ашигтай нээлт гарцаагүй хийнэ гэх итгэл байхгүй, ашигтай нээлт хийх эсэх нь тодорхойгүй, гэрээний талуудын хүсэл зоригоос хамааралгүй болзол болох нь тодорхой бөгөөд гэрээний талууд энэ талаар ойлголттой, мэдэж байсан нь тодорхой байна. Улмаар, биелэх эсэх нь тодорхойгүй болзлоос өртөг зардлыг нөхөж авах шаардах эрх нь шууд хамааралтайгаар үүсэх тул 4 дүгээр нөхцөлийн сүүлийн өгүүлбэрт “Ийм учраас энэхүү гэрээний дагуу үүсэх аливаа өртөг зардлыг Гэрээлэгч нөхөж авах баталгаа мөн байхгүй. – хэмээн өртөг зардлыг гэрээлэгч нөхөж авах нь тодорхой биш, гагцхүү “ашигтай нээлт хийх” болзол биелэхээс хамаарна гэдгийг дахин илэрхийлсэн байна.

АМГТГ-аас ирүүлсэн судалгаагаар Тосон уул XIX, Тамсаг XXI талбайн газрын тосноос 1997-2022 оны хооронд улсын төсөвт 2,012.4 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Тосон уул XIX, Тамсаг XXI талбайгаас 1997-2022 оны улсын төсөвт төвлөрүүлсэн газрын тосны орлого

Огноо	Тосон Уул XIX МУ-д ногдох тосны орлого	Тамсаг XXI		Улсын төсөвт төвлөрүүлсэн нийт тосны орлого
		ГТНАТ (роялти) 7.5%	МУ-д ногдох тосны орлого	
1997-2008	40,350.99	-	-	40,350.99
2009	24,889.30	44.87	125.63	25,059.80
2010	38,220.32	-	-	38,220.32
2011	59,101.39	811.25	2,271.51	62,184.15
2012	99,936.20	292.72	819.63	101,048.55
2013	131,822.83	8,236.23	23,137.04	163,223.10
2014	156,079.13	25,645.48	71,807.34	253,531.95
2015	77,586.54	18,719.81	52,404.08	148,710.42
2016	55,993.50	18,360.19	51,397.38	125,751.07
2017	77,766.79	29,552.51	82,729.05	190,048.35
2018	95,319.15	31,517.57	88,230.03	215,066.75
2019	95,799.41	30,210.11	84,569.95	210,579.48
2020	37,544.64	14,773.84	41,357.77	93,676.24
2021	78,465.85	28,876.67	80,837.12	188,179.64
2022	70,178.96	22,778.53	63,766.04	156,723.54
Нийт	1,139,055.01	229,819.78	643,452.56	2,012,354.34

Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газраас:

Аудитын явцад улсын төсөвт төвлөрүүлсэн 2,012.4 тэрбум төгрөгийг БХГ-ний 8.3-д заасны дагуу тооцоход нийт орлогын 24 орчим хувьтай тэнцэж байгаагаас гэрээлэгчид 76 хувь буюу 6,372.5 тэрбум төгрөг хуваарилагдаж, нийт орлого 8,384.8 тэрбум төгрөг байх тооцоолол гарч байна. /Хавсралт 1, 2/

Тосон уул XIX, Тамсаг XXI талбайн нийт зардлыг АМГТГ-ын 1993-2013 оны хяналт шалгалтын тайлангаар 1,983.5 сая ам.доллар, YAГ-аас хийсэн аудитаар 2014-2018 онд 1,299.0 сая ам.доллар, нийт 3,282.4 сая ам.долларын өртөг нөхөгдөх зардлыг тооцсон байна.

Хүснэгт 3. Өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын дүн

/мянган ам.доллар/

Үзүүлэлт	Талбай	Газрын тосны газар /хуучнаар/ баталгаажуулснаар 1993-2013 он	ҮАГ-ын баталгаажуулснаар 2014-2018 он	Нийт
Өртөг нөхөгдөх зардлын дүнгээр тооцсон /мянган ам.доллар/	Тосон Уул XIX	1,481,197.5	621,104.6	2,102,302.2
	Тамсаг XXI	502,284.9	677,856.2	1,180,141.1
	Дүн	1,983,482.4	1,298,960.9	3,282,443.3
Өртөгт тосоор нөхөж авсан дүн /мянган ам.доллар/	Тосон Уул XIX	473,851.8	370,027.8	843,879.5
	Тамсаг XXI	33,649.4	304,466.5	338,115.9
	Дүн	507,501.1	674,494.3	1,181,995.4
Нөхөгдөх боломжтой зардал /мянган ам.доллар/	Тосон Уул XIX	1,007,345.7	251,076.9	1,258,422.6
	Тамсаг XXI	468,635.6	373,389.7	842,025.3
	Дүн	1,475,981.3	624,466.6	2,100,447.9
Монгол банкны 2023.11.15-ны өдрийн ханшаар /сая төгрөг/		5,079,589.62	2,149,101.82	7,228,691.43

Эх сурвалж: АМГТГ-ын 1993-2013 оны хяналт шалгалтын тайлан, ҮАГ-ын аудитын тайлангаас:

Өртөг нөхөгдөх зардлаас 1,181.9 сая ам.долларыг өртөгт тосоор нөхөж авч, 2,100.4 сая ам.долларын зардлыг нөхөж хуваарилахаар тооцсон байна./1993-2018 он тус бүрээр дэлгэрэнгүйгээр Хавсралт 3-аас/

“Петрочайна Дачин Тамсаг” ХХК 2019-2022 оны нийт өртөг нөхөгдөх зардлыг 602.3 сая ам.доллар буюу /Монгол банкны тухайн оны хаалтын ханшаар/ 1,775.8 тэрбум төгрөгөөр гаргаж ирүүлсэн байна.

Хүснэгт 4. “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн 2019-2022 оны тайлагнасан ӨНЗ-ын дүн

ӨНЗ 2019-2022	мянган ам.доллар	сая төгрөг
2019 он /1\$=2.734.33/	215,694.4	589,779.7
2020 он /1\$=2,849.89/	121,551.9	346,409.4
2021 он /1\$=2,849.34/	123,502.4	351,900.2
2022 он /1\$=3,444.60/	141,600.0	487,755.4
Нийт	602,348.6	1,775,844.7

Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газраас:

Зураг 1. Орлого, зарлагын зөрүү



Орлого, зарлагын зөрүүгээс үзэхэд уг төсөл үр ашиггүй, 3.0 их наяд төгрөгийн алдагдалтай харагдаж байгааг АМГТГ-аас ирүүлсэн тоо мэдээлэл, судалгаанд үндэслэсэн бөгөөд байгаль орчны нөхөн сэргээгдэхгүй хохирлыг тооцоолоогүй болно.

АМГТГ дахь төслийн нийт үйл ажиллагаатай холбоотой мэдээ, судалгаа, архивын баримтын бүрдэл дутуу, БХГ-ний шаардлага хангахгүй байх бөгөөд эдгээр үйл ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй МУЗГ-ын төлөөлөгч буюу АМГТГ болон УУХҮЯ-ын холбогдох ажилтан, албан хаагчид ажилдаа хариуцлагагүй, хайнга хандсан зэргээс шалтгаалан гэрээлэгч өртөг зардлаа багасгаж, үр ашигтай ажиллахыг эрмэлзэхгүй байна.

Энэ нь БХГ-ний “С” хавсралт, “Тооцооны журам”-ын 1.1-д “Энэхүү бүртгэл тооцооны журмын зорилго нь гэрээний дагуу гарах, өртөг, зардал, бараа материалын нөөцийн орлого, зарлагыг тодорхойлох эрх тэгш арга замыг тогтооход оршино. Хэрэв эдгээр арга замын аль нэг нь гэрээлэгч буюу МУЗГ-ын хувьд шударга, эрх тэгш бус болох нь нотлогдвол талууд буцааж дээрх арга замын шударга, эрх тэгш бус аливаа зүйлийг залруулахад шаардлагатай өөрчлөлтүүдийн талаар тохиролцохыг хичээнгүйлэн эрмэлзэнэ” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

“Петрочайна Дачин Тамсаг” ХХК нь “Иргэний хуулийн 5.2-т “Шинээр баталсан хууль тогтоомж нь гэрээний нэг буюу хоёр талын эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулахаар бол гэрээний нөхцөл хүчин төгөлдөр байна” гэж заасан нь “хуулиар өнгөрснийг хөөн хэлэлцэхгүй” гэсэн үзэл санааг илэрхийлж байна. Олон улсын газрын тосны салбарын үйл ажиллагаанд улс дамнасан компанитай байгуулсан гэрээ болон хууль эрх зүйн орчныг аль ч улсын Засгийн газар дангаараа өөрчлөхийг хориглох зарчмыг баримталж ирсэн. Иргэний хуулийн дээр дурдсан заалтын дагуу БХГ-г байгуулсны дараа Монгол Улсын хууль яаж ч өөрчлөгдөж, тэрхүү өөрчлөлт нь БХГ-ээр олгогдсон эрх ашгийг хохироосон бол гэрээний зүйл заалтыг хүчинтэй хэвээр байлгаж, хуучин гэрээний зүйл заалтыг баримталж, хэрэгжүүлэх ёстой” гэж тайлбарладаг.

Гэрээлэгч ийнхүү тайлбарладаг хэдий ч БХГ-гээ бүрэн хэрэгжүүлж ажиллахгүй байхад БХГ-ний 21.3-д “Хэрэв гэрээлэгч нь мэдсээр атлаа энэ гэрээг зөрчвөл, ... МУЗГ энэ гэрээг цуцлах эрхтэй” гэж заасны дагуу тодорхой арга хэмжээ авч ажиллахгүй байна.

Дээрх нөхцөл байдлыг дүгнэхэд “**үр ашигтай нээлт**” илэрсэн нь баримтаар нотлогдоогүй бөгөөд тооцооллоор газрын тосны нийт орлого 8,384.8 тэрбум, нийт зардал 11,468.8 тэрбум, алдагдал 3,084.0 тэрбум төгрөг байхад техник эдийн засгийн хувьд үр ашигтай гэж үзэн 7,228.7 тэрбум төгрөг/2019-2022 оны баталгаажуулахаар хүлээгдэж буй 1,775.8 тэрбум/ нийт 9,004.5 тэрбум төгрөгийн өртөг нөхөгдөх зардлыг хуримтлуулж баталгаажуулах нь БХГ-ний 4 дүгээр зүйлд заасныг зөрчиж байна.

Иймд талууд зайлшгүй шаардлагатай асуудлаар БХГ-д өөрчлөлт оруулахгүй, тодорхой арга хэмжээ авахгүй байгаа нь бусдад давуу байдал олгох үйлдэл, эс үйлдэхүй байж болзошгүй тул хууль хяналтын болон бусад байгууллагад шилжүүлэв.

Үүнтэй холбоотойгоор ТАБ-аас “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн 2019-2021 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтыг баталгаажуулахгүй байхаар шийдвэрлэв.

Мөн газрын тосны үйл ажиллагааны явцад гэрээлэгч хариуцах зардлыг үр ашигтай нээлт гэж нөхөж авахаар буруу тооцон 2018 оны жилийн эцсийн байдлаар хуримтлуулсан 2,100.4 сая ам.долларын өртөг зардлыг МУЗГ Бүтээгдэхүүн хуваах нөхцөлөөр нөхөж төлөхгүй байхаар аудитаар баталгаажуулж байгааг гэрээлэгчид мэдэгдэж тооцоо нийлэх, цаашид зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй ажиллах албан шаардлагыг АМГТГ-т хүргүүллээ.

1.2. Тосон Уул XIX талбайн ӨНЗ-ыг 1996 оноос нөхөж авснаар үр ашигтай нээлт бүртгэгдсэн гэж тооцвол БХГ-ний хүчин төгөлдөр хугацаа дууссан байна.

БХГ-нд гэрээний хүчин төгөлдөр байх хугацааг дараах байдлаар заасан байна. Үүнд:

БХГ-ний 5 дугаар зүйлийн 5.1-д "Хайгуулын анхны үе нь гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхэлнэ. Хайгуулын анхны үеийн эхний болон хоёр дахь шат тус бүр хоёр (2) жил байна. Гурав дахь шат нь нэг (1) жил байна", 5.2.в-д "Хэрэв хайгуулын гурав дахь үе буюу эсвэл сүүлийн сунгасан хугацаа дуусах өдөр үр ашигтай болох нь тодорхой болоогүй нээлтийн цооног байгаа бол уг нээлтийн цооног байгаа үнэлгээний талбайн хувьд хайгуулын эцсийн хугацаа нь дараах нөхцөлүүдийн аль нэг нь түрүүлж тохиолдох хүртэл хүчин төгөлдөр үргэлжилнэ. Үүнд:

1. Тухайн нээлтийг үр ашигтай нээлт гэж тогтоох,
2. Тухайн нээлтийг үр ашигтай биш нээлт гэж тогтоох, эсвэл
3. Хайгуулын 3 дахь ба эцсийн хугацаа дуусах ёстой өдрөөс хойш нэг (1) жил өнгөрөх зэрэг болно"

БХГ-ний 5 дугаар зүйлийн 5.4-д "Үр ашигтай нээлтүүд Хэрэв нэг буюу хэд хэдэн нээлтийн цооногоор илрүүлсэн нэг буюу хэд хэдэн үр ашигтай нээлт гэж тогтоогдвол гэрээлэгч 15 хоногийн дотор ... мэдэгдэх бөгөөд ингэж мэдэгдсэн өдөр нь тухайн үр ашигтай нээлтийг бүртгэсэн өдөр болно";

Мөн БХГ-ний 5 дугаар зүйлийн 5.5-д Олборлолтын хугацааг "... энэ гэрээ үр ашигтай нээлт **нэг бүрийн хувьд**, тухайн үр ашигтай нээлтийг бүртгэсэн өдрөөс хойш 20 жилийн хугацаа (олборлолтын хугацаа)-нд хүчин төгөлдөр байна" гэж заасан бөгөөд үр ашигтай нээлт бүртгэгдсэн тохиолдолд ӨНЗ-ыг нөхөж авахаар тус тус заасан байна.

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

Гэвч гэрээний талууд бодит нөхцөл байдалд хайгуулын хугацааг хэрхэн сунгасан, олборлолтод хэзээ шилжсэн, хэзээ дуусах талаар үндэслэлтэй тайлбар, тодруулга, нотлох баримтыг гаргаж чадахгүй байна.

Аудитаар үр ашигтай нээлтийн бүртгэлийн баримт байхгүйг үл харгалзан гэрээний талууд анх газрын тос олборлож эхэлсэн цооногуудын хувьд, “**үр ашигтай нээлт**” гэж харилцан хүлээн зөвшөөрч, экспортолж эхэлсэн буюу ӨНЗ нөхөж авсан хугацаагаар тооцвол БХГ-ний 5 дугаар зүйлд заасан гэрээний хүчин төгөлдөр хугацаа дууссан байна. Тухайлбал:

Зураг 2. Тосон Уул XIX талбайн хугацааг тоолбол:



- Тосон Уул XIX талбайд ӨНЗ-ыг анх нөхөж авсан 1996 оноос тооцвол 2016 онд анхны үр ашигтай цооногийн хугацаа дуусаж, үр ашигтай нээлт бүртгэгдэх сүүлийн хугацаагаар тооцвол 2023 оны 4 дүгээр сард Тосон Уул XIX талбайн БХГ-ний хугацаа бүрэн дууссан;
- Тамсаг XXI талбайд ӨНЗ-ыг анх нөхөж авсан 1997 оноос тооцвол 2017 онд анхны үр ашигтай цооногийн хугацаа дуусаж, үр ашигтай нээлт бүртгэгдэх сүүлийн хугацаагаар тооцвол 2025 оны 12 дугаар сард Тамсаг XXI талбайн БХГ-ний хугацаа бүрэн дуусахаар байна.

Мөн Австралийн Комманд Петролеум компаниар толгойлуулсан олон улсын газрын тосны консорциум нь “СОКО Монгол Инк”-д эрхээ шилжүүлсэн тухай болон Соко Тамсаг Монгол ХХК-иас Дачин Ойлфилд Лимитед компанид эрх шилжүүлсэн тохиролцоо нь БХГ-ний 24 дүгээр зүйлд эрх шилжүүлэлтийг МУЗГ-ын бичгээр өгсөн зөвшөөрлийн дагуу олгохоор заасныг зөрчиж байна.


Ашигт малтмал, газрын тосны газар /хуучнаар Газрын тосны хэрэг эрхлэх газар/ хуулиар олгогдоогүй эрх эдэлж гэрээлэгчтэй 2004 онд нэмэлт хэлэлцээр хийж хайгуулын хугацааг 5 хүртэл жилээр сунгахаар тохиролцсон нь БХГ-тэй нийцэхгүй байна.

Иймд АМГТГ-т БХГ-г үндэслэн үр ашигтай нээлт гэж тооцсон цооног тус бүрийн хугацааг нарийвчлан тогтоож бүртгэлжүүлэх, Тосон Уул XIX талбайгаас олборлосон газрын тосны экспортлох үйл ажиллагааг зогсоох арга хэмжээ авах, цаашид зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах албан шаардлагыг хүргүүлээ.

1.3. “Петрочайна Дачин Тамсаг” ХХК газрын тостой холбогдсон бүх үйл ажиллагаанд хамаарах ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд иж бүрэн, үнэн зөв тайлагнаагүй, түүнийг хянах байгууллагууд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй байна

“Петрочайна Дачин Тамсаг” ХХК газрын тостой холбогдсон бүх үйл ажиллагаанд хамаарах ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд иж бүрэн, үнэн зөв тусгаж бүртгээгүйгээс аудитлагдсан санхүүгийн тайлангийн нийт зардлын дүн /тухайн үеийн Монгол банкны ханшаар хөрвүүлэн тооцоход/ ӨНЗ-ын тайлангийн гүйцэтгэлээс 2019 онд 198.8 сая, 2020 онд 109.9 сая ам.доллаароор тус тус дутуу, 2021 онд 15.1 сая ам.доллаароор илүү тайлагнасан байна.

График 1. Аудитлагдсан санхүүгийн тайлангийн зардлын дүнг ӨНЗ-ын дүнгийн харьцуулалт



Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газар, СЯ-ны e-тайлан:

Өөрөөр хэлбэл борлуулалтын орлого, газрын тосны үйл ажиллагаанд хамаарах зардлыг санхүүгийн тайланд тусгаагүй, ӨНЗ-ын гүйцэтгэл нь санхүүгийн тайлантай уялдаагүй, зардлыг хэт өндөр тайлагнасан байна.

Энэ нь БХГ-ний 13 дугаар зүйлийн 13.1.а-д “Гэрээлэгч газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд хамаарах нягтлан бодох бүртгэлийг “С” хавсралтад заасан тооцооны журам болон олон улсын газрын тосны үйлдвэрлэлд хэвшсэн нягтлан бодох бүртгэлийн нийтлэг зарчмуудын дагуу хөтөлнө”, Газрын тосны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 36 дугаар зүйлийн 36.2-д⁶, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д⁷ заасныг тус тус зөрчсөн байна.

Нөгөө талаас АМГТГ нь гэрээлэгчийн тайлагнасан ӨНЗ-ын гүйцэтгэлийг хянаж, дүгнэлт ирүүлэхдээ санхүүгийн тайланг хянаагүй нь Газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д⁸ заасан үүргээ хэрэгжүүлээгүй байна.

⁶ “Гэрээлэгч нь тусгай зөвшөөрөлтэй талбайд хийгдэж байгаа газрын тостой холбогдсон бүх үйл ажиллагааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаж, тайлагнана”;

⁷ “Монгол улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллага, гадаадын ААНБ-ын төлөөний газар нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана”;

⁸ “Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага анхан шатны баримтад үндэслэн гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтын болон санхүүгийн тайланг хянан шалгаж, дүгнэлт гаргасан тайлангаа төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ”.

Мөн Сангийн яам нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт мөрдөх үүрэгтэй аж ахуйн нэгж, байгууллага энэхүү стандартыг хэрхэн мөрдөж байгаад харилцагч санхүүгийн байгууллагатай хамтран хяналт тавих хуулиар хүлээсэн чиг үүргээ биелүүлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1⁹, 17.1.7¹⁰-д заасантай нийцэхгүй байна.

Иймд Сангийн яаманд газрын тосны салбарт олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагад санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг мөрдүүлэх, харилцагч санхүүгийн байгууллагатай хамтран хяналтыг хэрэгжүүлж байх, дээрх зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад хуулиар хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлээгүй холбогдох албан тушаалтнуудад сахилгын шийтгэл тооцуулах албан шаардлагыг тус тус хүргүүлэхээр шийдвэрлэв.

⁹ "Санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ",

¹⁰ "энэ хуульд заасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт мөрдөх үүрэгтэй аж ахуйн нэгж, байгууллага энэхүү стандартыг хэрхэн мөрдөж байгаад харилцагч санхүүгийн байгууллагатай хамтран хяналт тавих"

БҮЛЭГ 2. ГЭРЭЭЛЭГЧИЙН БАТЛАГДСАН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨСӨВ, ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ГАЗРЫН ТОСНЫ ЭКСПОРТ, БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО ЗӨРҮҮТЭЙ БАЙХАД АМГТГ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ДҮГНЭЛТ ТАЙЛАНДАА ТУСГААГҮЙ БАЙНА

2.1. АМГТГ-ын дүгнэлт, тайлан хуулийн шаардлага хангахгүй байна

Газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д “Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага анхан шатны баримтад үндэслэн гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтын болон санхүүгийн тайланг хянан шалгаж, дүгнэлт гаргасан тайлангаа төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ” гэж заасан.

АМГТГ-аас “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн 2019-2022 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажлын хяналт шалгалтын дүгнэлт, тайланг дараах байдалтай ирүүлсэн байна. Үүнд:

Хүснэгт 5. АМГТГ-аас ирүүлсэн дүгнэлт, тайлангийн үзүүлэлт

№	Хянан шалгаж дүгнэлт тайлан ирүүлэх үзүүлэлт	Анхан шатны баримтад үндэслэсэн эсэх	Бүрэн хянаж дүгнэсэн эсэх	АМГТГ-аас ирүүлсэн тайлан, дүгнэлтийг хянаж үзэхэд
1	Батлагдсан төлөвлөгөө, гүйцэтгэл	Тийм	Дутуу	Гэрээлэгч 2019-2021 онд нийт 1,016.9 сая ам.долларын төсөв батлуулсан. Төлөвлөгөөт ажлын гүйцэтгэлийг тоо хэмжээгээр ажил тус бүрээр гаргасан. Төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэлд үүссэн зөрүү, хийгдээгүй ажлын талаар хариуцсан мэргэжилтнүүдээс санал дүгнэлтийг хавсаргасан боловч төсвийн гүйцэтгэлийг гаргаагүй, нэгтгэж дүгнэлт тайланд тусгаагүй байна.
2	Батлагдсан төсөв, гүйцэтгэл	Тийм	Дутуу	
3	Хөрөнгө оруулалт	Үгүй	Үгүй	Хөрөнгө оруулалт, ӨНЗ-ыг хамтруулан нэг бүлэг асуудал болгон тайлагнасан. Зөвхөн ӨНЗ-ыг баримт материалтай тулгаж шалгасан тайланг ирүүлсэн. Гэрээлэгчийн 2019 оны ӨНЗ-ын хэмжээг хянасан дүгнэлтдээ 0.6 сая ам.долларын арифметик алдаатай ирүүлсэн.
4	Өртөг нөхөгдсөн зардал	Үгүй	Үгүй	
5	Нөхөгдөх зардал	Тийм	Буруу	Газрын тосны экспортын өдөр тутмын баримт, гэрээний 2 талын тооцоо нийлсэн протоколын дүн зөрүүтэй.
6	Газрын тосны экспорт	Тийм	Дутуу	
7	Борлуулалтын орлого	Тийм	Дутуу	
8	Хуваарилалт	Үгүй	Буруу	АМГТГ нь гэрээлэгчийн санхүүгийн тайланг хянан шалгаж, дүгнэлт тайлан ирүүлээгүй.
9	Санхүүгийн тайлан	Үгүй	Үгүй	

АМГТГ нь гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажлын баримтад үндэслэсэн боловч санхүүгийн тайлантай хянаж дүгнээгүй байна. Тухайлбал:

АМГТГ “Хөрөнгө оруулалт-ӨНЗ” гэсэн нэг дэд хэсэг болгон нэгтгэн ӨНЗ-ын хэмжээг хянасан байна.

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

Гэтэл гэрээлэгч санхүүгийн тайлан, тодруулгад 2019 онд 0.066 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт, 2020 онд хөрөнгө оруулалт хийгдээгүй, 2021 онд дахин үнэлгээний нэмэгдэл тооцсон нийт 4,219.8 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалт мэтээр тайлагнаж, ӨНЗ санхүүгийн тайлан, тодруулгад тусгаж тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 зүйлийн 5.1.4¹¹-д заасныг зөрчиж байна.

Аудитыг Газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3-д “Төрийн аудитын байгууллага энэ хуулийн 37.2-т заасан аудитыг гүйцэтгэхдээ хараат бус шинжээч, мэргэжилтэн, аудитын хуулийн этгээдийг оролцуулж болно” гэж заасны дагуу аудитын хуулийн этгээдтэй гэрээ байгуулан ажилласан бөгөөд АМГТГ-ын хяналт шалгалтын тайлан, дүгнэлтийг хянаж үзээд илэрсэн зөрчлийн дүнг энэхүү бүлэгт тусгалаа.

АМГТГ-ын дүгнэлт, тайлангаарх Газрын тосны экспортын тоо хэмжээг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 6. Газрын тосны экспорт

/мянган баррель, мянган тонн, мянган ам.доллар/

Үзүүлэлт	Гэрээлэгчийн тайлагнаснаар			АМГТГ дүгнэлтээр		
	баррель	тонн	ам.доллар	баррель	тонн	ам.доллар
Тосон Уул XIX талбай						
2019 он	3,098.0	420.3	173,008.9	3,098.0	420.3	173,008.9
2020 он	1,602.6	213.6	61,419.5	1,602.6	213.6	61,419.5
2021 он	1,924.8	273.6	119,789.1	1,924.8	273.6	119,789.1
Дүн	6,625.4	907.5	354,217.5	6,625.4	907.5	354,217.5
Тамсаг XXI талбай						
2019 он	3,076.6	458.9	171,852.5	3,076.6	458.9	171,852.5
2020 он	2,109.1	294.6	76,179.0	2,109.1	294.6	76,179.0
2021 он	2,178.5	314.8	136,855.2	2,178.5	314.8	136,855.2
Дүн	7,364.2	1,068.3	384,886.8	7,364.2	1,068.3	384,886.8
Нийт дүн	13,989.6	1,975.8	739,104.3	13,989.6	1,975.8	739,104.3

Эх сурвалж: АМГТГ-ын ирүүлсэн 2019, 2020, 2021 оны дүгнэлт, тайлангаас

Аудитаар АМГТГ болон “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн хооронд 2019-2021 оны хий, тос, усны олборлолт, ачилт буулгалтын баталгаажуулсан тоо хэмжээг өдөр тутмын ачилт, буулгалтын мэдээ болон гаалийн мэдээтэй тулган шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- АМГТГ болон “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн хооронд Тосон Уул XIX талбайгаас 2019 онд олборлосон хий, тос, усны тооцоо нийлж баталгаажуулсан протоколд “Дорнын хөгжил транспорт” ХХК-ийн 2019.03.30-ны өдрийн 1 автомашин 284.53 баррель тос асгарсныг экспортоос хасаж баталгаажуулсан;
- Ачилтын мэдээ болон гаалийн мэдээний хугацааг 1-27 өдрөөр зөрүүтэй мэдээлсэн байна. Тухайлбал: Тамсаг XXI талбайн 2019, 2020 оны ачилтын мэдээний Амберын хэмжилтээрх тоо хэмжээг гаалийн мэдээгээрх тоо хэмжээтэй тулгахад ачилтын мэдээнд ороогүй 1,854.6 баррель тосны зөрүү байна.
- БХГ-ний дагалдах Хоёр талбайн экспортолж байгаа түүхий тосны хэмжилтийг тохиролцсон 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн протокол нь 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хүчинтэй байх бөгөөд протоколын хүчинтэй хугацаа дуусгавар болох үед талууд харилцан тохиролцож сунгахаар заасан боловч 2020 онд экспортлож буй түүхий тосны хэмжилт болон МУЗГ-т ногдох түүхий тосны борлуулалтын орлогыг тооцох асуудлаар тохиролцсон хүчин төгөлдөр эрх зүйн баримт бичиггүй байна.

¹¹ 5.1.4.үнэн зөв байх;

Энэ нь Газрын тосны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.8-д “гэрээлэгчийн тухайн жилийн хөрөнгө оруулалт, зардал, нөөц ашигласны төлбөр, олборлосон болон борлуулсан газрын тосны тайланг хянаж нэгтгэх”, 11 дүгээр зүйлийн 11.2.14-д “санхүүгийн тайлан, өртөг нөхөгдөх зардлын тайлан, газрын тос хуваах тооцоог ... үнэн зөв гаргаж, төрийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгөх” гэж тус тус заасантай нийцэхгүй байна. Иймд дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

АМГТГ-ын дүгнэлт, тайлангаарх Газрын тосны борлуулалтын орлогыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 7. Борлуулалтын орлого

/Мянган баррель, мянган ам.доллар/

Үзүүлэлт	Гэрээлэгчийн тайлагнаснаар		АМГТГ дүгнэлтээр	
	баррель	ам.доллар	баррель	ам.доллар
Тосон Уул XIX талбай				
2019 он	3,067.4	172,923.9	3,087.7	174,068.5
2020 он	1,587.8	61,480.2	1,598.6	61,899.4
2021 он	1,911.4	119,017.2	1,919.5	119,529.1
Дүн	6,566.6	353,421.4	6,605.8	355,497.0
Тамсаг XXI талбай				
2019 он	3,052.6	172,005.5	3,073.5	173,218.5
2020 он	2,092.2	76,064.3	2,106.1	76,572.0
2021 он	2,161.5	135,517.3	2,176.1	136,420.6
Дүн	7,306.2	383,587.1	7,355.7	386,211.0
Нийт дүн	13,872.8	737,008.5	13,961.5	741,708.1

Эх сурвалж: АМГТГ-ын ирүүлсэн 2019, 2020, 2021 оны дүгнэлт, тайлангаас:

Гэрээлэгч 2019-2021 онд 13.9 сая баррель тос буюу 737.0 сая ам.доллаароор борлуулсан гэж тайлагнасныг АМГТГ 0.09 сая баррель тос буюу 4.7 сая ам.доллаароор нэмэгдүүлж дүгнэсэн нь техникийн хорогдлын хувь хэмжээг тохироогүйгээс шалтгаалсан байна.

Аудитаар борлуулалтын орлогын холбогдох баримт, материалд үндэслэн тулган баталгаажуулалт, тооцоолол хийж, дараах зөрчлийг илрүүллээ. Үүнд:

- Гэрээлэгч нь 2019-2021 онд Борлуулалтын тайланд борлуулсан тосонд технологийн хорогдол тооцож хасан Тосон Уул XIX талбайд 39,438.2 баррель тос буюу борлуулсан тосны орлогыг 2,090,688.2 ам.доллар, Тамсаг XXI талбайд 49,837.5 баррель тос буюу борлуулсан тосны орлогыг 2,648,217.0 ам.доллар нийт 4,738,905.2 ам.доллар дутуу тооцсон;
- Гэрээлэгч 2019-2021 онд Тосон Уул XIX талбайд ГТНАТ тооцоогүй тул өмнөх аудитын тогтоосон 5.0 хувиар тооцоход 15,570,205.1 ам.долларын төлбөр төсөвт төвлөрүүлээгүй;
- Тамсаг XXI талбайд тооцсон ГТНАТ нь тооцооллын зөрүүгээс шалтгаалан 2019-2021 онд 299,481.2 ам.долларын төлбөр дутуу тооцсон;
- Гэрээлэгч, АМГТГ нь экспортын тээврийн зардлыг хүргэлтийн цэг дэх буулгалтын огноогоорх ASMT1250-820 хүснэгтээр тооцсон баррель тосны хэмжээг тээврийн гэрээний нэгж үнээр тооцон баталгаажуулсан байна. Экспортын тээврийн хөлсний тооцоог компани тус бүрээр дэлгэрэнгүй бүртгэл хөтлөөгүй, төлбөрийн нэхэмжлэлд нэгжийн үнийг гэрээнээс зөрүүтэй дүнгээр тооцсон, өглөгийн журналд зөвхөн эхний, эцсийн үлдэгдлийг бүртгэсэн байна. Аудитын тулгалтаар 2 талын тооцоо нийлж борлуулалтын тайланд баталгаажуулсан дүнг тээврийн компаниудтай тооцоо нийлээгүй, гэрээ дүгнэсэн акт хавсаргаагүй, нотлох баримт дутуу, Тосон Уул XIX талбайд 601,725.2 ам.доллар, Тамсаг XXI талбайд 1,425,377.1 ам.доллар, нийт 2,027,102.3 ам.долларын зардал илүү тайлагнасан;
- Гэрээлэгч 2020 онд Тосон-Уул XIX талбайн 339,243.40 ам.доллар, Тамсаг XXI талбайн 728,392.40 ам.долларын ус ашигласан төлбөр төлөөгүй байна.

Борлуулалтын орлоготой холбоотой нийт 21.7 сая ам.долларын зөрүү гарсан боловч өмнөх аудитаар илэрсэн дээрх зөрчилд 30.4 сая ам.долларын төлбөрийн

актыг биелүүлээгүй тул холбогдох албан тушаалтанд сахилгын шийтгэл оногдуулах, МУЗГ-т гэрээлэгч БХГ-г удаа дараа зөрчиж, аудитаар өгсөн албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байгаа тул БХГ-ний 21 дүгээр зүйлийн 21.3-д заасны дагуу гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авч ажиллах зөвлөмж өглөө.

2.2. Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр зохицуулаагүй байхад газрын тос борлуулахтай холбоотой гарсан зардлыг суутгасны дараа хуваах тосыг тооцсон байна

Гэрээлэгч 2019-2021 онд Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайгаас газрын тос борлуулахад нийт 83.1 сая ам.долларын борлуулалттай холбоотой зардал тооцож тайлагнасныг АМГТГ 82.7 буюу 0.4 сая ам.доллаароор бууруулж, хянаж ирүүлсэн.

Хүснэгт 8. Газрын тос борлуулахтай холбоотой гарсан зардал /2019-2021 он/

Үзүүлэлт	Тосон Уул XIX		Тамсаг XXI		Нийт	
	Гэрээлэгч тайлагнасан наар	АМГТГ дүгнэлтээр	Гэрээлэгч	АМГТГ дүгнэлтээр	Гэрээлэгч	АМГТГ дүгнэлтээр
I. Буулгалтын зардал	1,478.3	1,474.2	1,643.2	1,639.0	3,121.5	3,113.3
II. Хяналтын зардал	132.0	131.6	146.7	146.3	278.7	278.0
III. Халаалтын зардал	4,335.8	4,336.2	4,777.3	4,778.6	9,113.1	9,114.8
IV. Ус ялгалтын зардал	2.7	14.0	-	40.9	2.7	54.9
V. Банкны үйлчилгээний зардал	-	-	2.0	-	2.0	-
Нийт дүн	5,948.8	5,956.1	6,569.2	6,604.9	12,518.1	12,561.0

/мянган ам.доллар/

Эх сурвалж: АМГТГ-ын ирүүлсэн 2019, 2020, 2021 оны дүгнэлт, тайлангаас

АМГТГ-ын дүгнэлт тайлангаарх тээврийн зардлыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 9. Тээврийн зардал /2019-2021 он/

Он	Тосон Уул XIX		Тамсаг XXI		Нийт дүн	
	Гэрээлэгч	АМГТГ дүгнэлтээр	Гэрээлэгч	АМГТГ дүгнэлтээр	Гэрээлэгч	АМГТГ дүгнэлтээр
2019	18,179.40	17,732.02	14,622.15	14,622.15	32,801.55	32,354.17
2020	9,705.09	9,727.45	8,607.66	8,608.78	18,312.75	18,336.23
2021	10,858.36	10,839.46	8,641.53	8,639.28	19,499.89	19,478.75
Дүн	38,742.85	38,298.94	31,871.34	31,870.22	70,614.19	70,169.15

/мянган ам.доллар/

Эх сурвалж: АМГТГ-ын ирүүлсэн 2019, 2020, 2021 оны дүгнэлт, тайлангаас

АМГТГ нь борлуулалттай холбоотой зардал 12.6 сая, тээврийн зардал 70.2 сая, нийт 82.7 сая ам.долларын борлуулахтай холбоотой гарсан зардал гэж суутгаж хуваах тосыг тооцсон нь БХГ-ний үндсэн зарчмыг алдагдуулсан байна.

Энэ нь БХГ-ний 8 дугаар зүйлийн 8.3-д “Хуанлийн сард ногдох өртөгт тосны нийт хэмжээг хасаад үлдсэн бүх гэрээт түүхий тос (Хуваах тос)-ыг МГТ компани болон гэрээлэгчийн хооронд тухайн хуанлийн сард гаргасан хуваах тосны өдрийн дундаж хэмжээнд тулгуурлан дор заасан харьцаагаар хуваана”, БХГ-ний 2.2-д

тодорхойлолтуудад “хуваах тос” гэж олборлосон нийт тосноос төлбөр (Роялти) болон өртөгт тосыг хасаад үлдэх хэсгийг хэлнэ” гэж заасныг зөрчиж байна.

Мөн БХГ-ний 4 дүгээр зүйлд “Гэрээнд өөрөөр заагаагүй бол газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад шаардагдах бүх өртөг, зардлыг гэрээлэгч хариуцна...”, гэрээний нөхцөлд дурдагдсан газрын тостой холбогдсон үйл ажиллагаа гэсэн ойлголтыг БХГ-ний 2.2-д тодорхойлолтуудад “Газрын тостой холбоотой үйл ажиллагаа” гэж газрын тос хайх, олборлох, боловсруулах, тээвэрлэх, хадгалах, борлуулахтай холбоотой ажиллагааг хэлнэ” гэж тус заасантай нийцэхгүй байна.

Гэрээлэгч, Ашигт малтмал, газрын тосны газар /хуучнаар Газрын тосны хэрэг эрхлэх газар/ хооронд 2004 онд байгуулсан түүхий тос тээвэрлэх, борлуулах тухай протоколоор борлуулалтын зардлыг Монголын талаас эргүүлэн авахаар тохирсон нь БХГ-тэй нийцээгүй, уг хэлэлцээр нь хүчин төгөлдөр эрх зүйн баримт бичиг болох нь тодорхойгүй байна.

Иймд БХГ-ний холбогдох заалтыг зөрчиж хянаж ирсэн энэ тооцооллыг хүлээн зөвшөөрөх боломжгүй төдийгүй өмнөх онуудад борлуулалтын орлогоос суутгасан “борлуулалтын зардал” гэх зардлыг хасаж бүтээгдэхүүн хувааж байгааг таслан зогсоож, БХГ-г мөрдөж ажиллах албан шаардлагыг АМГТГ-т хүргүүлэв.

Хүснэгт 10. Өртөг нөхөгдөх зардал /2019-2021/

/мянган ам.доллар/

Он	Гэрээлэгчийн тайлагнасан			АМГТГ дүгнэлтээр			Зөрүү /+нэмсэн, -хассан/
	ӨНЗ	Эх компанийн зардал	Нийт ӨНЗ	ӨНЗ	Эх компанийн зардал	Нийт ӨНЗ	
Тосон Уул XIX талбайн 2019-2021 оны өртөг нөхөгдөх зардал							
2019	106,306.4	10,630.6	116,937.0	46,866.3	4,686.6	51,552.9	(65,384.1)
2020	57,430.4	5,743.0	63,173.4	20,007.9	2,000.8	22,008.7	(41,164.7)
2021	56,760.4	5,676.0	62,436.4	75,590.5	7,559.0	83,149.5	20,713.1
Дүн	220,497.1	22,049.7	242,546.8	142,464.7	14,246.5	156,711.1	(85,835.7)
Тамсаг XXI талбайн 2019-2021 оны өртөг нөхөгдөх зардал							
2019	89,779.8	11,535.7	101,315.5	44,586.3	4,458.6	49,045.0	(52,270.5)
2020	53,071.3	5,307.1	58,378.5	16,035.9	1,603.6	17,639.5	(40,739.0)
2021	55,514.5	5,551.5	61,066.0	67,734.4	6,773.4	74,507.8	13,441.8
Дүн	198,365.6	22,394.3	220,759.9	128,356.6	12,835.7	141,192.2	(79,567.7)
Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайн 2019-2021 оны өртөг нөхөгдөх зардал							
2019	196,086.2	22,166.3	218,252.5	91,452.6	9,145.3	100,597.9	(117,654.6)
2020	110,501.7	11,050.2	121,551.9	36,043.8	3,604.4	39,648.2	(81,903.7)
2021	112,274.9	11,227.5	123,502.4	143,324.8	14,332.5	157,657.3	34,155.0
Дүн	418,862.7	44,444.0	463,306.7	270,821.2	27,082.1	297,903.3	(165,403.4)

Эх сурвалж: АМГТГ-ын ирүүлсэн 2019, 2020, 2021 оны дүгнэлт, тайлангаас

АМГТГ нь гэрээлэгчийн 2019-2021 онд тайлагнасан 463.3 сая ам.долларыг хянаж, цооног засвар үйлчилгээ, машин туслах тоног төхөөрөмж болон үйл ажиллагааны зардлыг И баримтгүй, Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.6-г зөрчсөн гэж үзэж нийт дүнгээр 165.4 сая ам.доллар буюу 35.7 хувийг хасаж дүгнэсэн байна.

Хассан зардлыг задалж үзвэл 147.0 сая ам.доллар буюу 60.7 хувь төлбөр төлсөн үед ӨНЗ-д тооцох өглөгийн дүн гэж хянасан боловч энэ нь нягтлан бодох бүртгэлд бүртгэж, санхүүгийн тайланд өр төлбөрөөр тайлагнаагүй байна. Өөрөөр

хэлбэл баталгаажаагүй өглөгийг хассан нэр зүүж, буцааж дараагийн жилүүдэд ӨНЗ-д нэмж тооцсон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.3-д “бүх өр төлбөр” гэсэн заалттай нийцэхгүй байна.

АМГТГ-ын хяналт, шалгалтаар гэрээлэгчийн 2019-2021 оны өртөг нөхөгдөх зардлын хэмжээ дараах байдалтай байна. /Дэлгэрэнгүйг Хавсралт 4-ээс/

Хүснэгт 11. АМГТГ-ын хяналт, шалгалтаар гэрээлэгчийн 2019-2021 оны өртөг нөхөгдөх зардлын хэмжээ

/мянган ам.доллар/

Хөрөнгө оруулалт-ӨНЗ тайлан	Мөр дугаар	Тосон Уул XIX	Тамсаг XXI	Дүн
Гэрээлэгчийн ӨНЗ тайлангаар	A	220,497.1	198,365.6	418,862.7
Гэрээлэгчийн захиргааны зардал тайлангаар	B	22,049.7	22,394.3	44,444.0
Гэрээлэгчийн тайлагнасан нийт ӨНЗ	C=A+B	242,546.8	220,759.9	463,306.7
Хасагдсан: Үүнээс	D=E+F+G	(125,989.8)	(116,181.9)	(242,171.8)
1. Төлбөр төлөх үед ӨНЗ-д тооцохоор хассан	E	(74,226.4)	(72,785.0)	(147,011.4)
2. Бусад үндэслэлээр хасагдсан	F	(22,595.2)	(19,837.2)	(42,432.4)
3. Ашиглаагүй бараа материал	G	(29,168.2)	(23,559.7)	(52,728.0)
Хассаны дараах ӨНЗ-ын дүн	H=A+D	94,507.3	82,183.6	177,216.1
Нэмсэн: Үүнд	I=J+K	47,957.4	46,172.9	94,130.3
1. 2019, 2020 оны өглөгөөс ӨНЗ-д тооцох дүн	J	43,590.7	53,499.4	97,090.0
2. 2019, 2020 оны өглөгөөс төлөгдсөн ӨНЗ-аас хасагдсан дүн	K	4,366.7	(7,326.4)	(2,959.7)
Нэмсэний дараах ӨНЗ-ын дүн	L=H+I	142,464.7	128,356.6	271,346.4
Захиргааны зардал 10 %	M=L*10 %	14,246.5	12,835.7	27,134.6
Нийт дүн ӨНЗ-ийн дүн	N=L+N	156,711.1	141,192.2	297,903.3
Тухайн жилд өртөгт тосоор нөхөгдсөн	O	(83,363.0)	(103,169.3)	(186,532.3)
ӨНЗ-ын нийт дүн	P=N+O	73,348.1	38,022.9	111,371.0

Эх сурвалж: АМГТГ-ын ирүүлсэн 2019, 2020, 2021 оны дүгнэлт, тайлангаас:

Түүнчлэн тухайн жилийн ӨНЗ-ын нийт дүнгээс өртөгт тосоор нөхсөн дүн их бол илүү гарсан ӨНЗ-ын дүнг хуримтлуулан тооцсон бол эсрэгээрээ тухайн жилийн ӨНЗ-ын нийт дүн 40 хувиас бага гарсан байхад 40 хувиар суутгаж, зөрүүг тооцохгүй байгаа нь БХГ-ний 8.2.а-д заасантай нийцэхгүй байна. Тухайлбал:

Хүснэгт 12. АМГТГ-ын хянаж шалгасан Гэрээлэгчийн 2020 оны өртөг нөхөгдөх зардлын хэмжээ

/мянган ам.доллар/

Хөрөнгө оруулалт-ӨНЗ	Мөр дугаар	Тосон Уул XIX	Тамсаг XXI	Нийт дүн
ӨНЗ тайлангаар	A	57,430.4	53,071.3	110,501.7
Хасагдсан	B	(30,972.6)	(29,515.5)	(60,488.1)
Ашиглаагүй бараа материал	C	(10,831.4)	(9,448.1)	(20,279.5)
ӨНЗ-ын дүн	D=A+B+C	15,626.4	14,107.7	29,734.1
2019 оны өглөгөөс төлөгдсөн дүн	E	4,381.5	1,928.2	6,309.7
Дүн	F=D+E	20,007.9	16,035.9	36,043.8
Захиргааны зардал 10 %	G=F*10%	2,000.8	1,603.6	3,604.4
Нийт дүн	H=F+G	22,008.7	17,639.5	39,648.2
Тухайн жилд өртөгт тосоор нөхөгдсөн	I	(20,289.6)	(26,419.5)	(46,709.1)
ӨНЗ-ын нийт дүн	J=I+H	1,719.1	(8,780.0)	(7,061.0)

Эх сурвалж: АМГТГ-ын ирүүлсэн 2019, 2020, 2021 оны дүгнэлт, тайлангаас:

Гэрээлэгчийн 2020 оны хөрөнгө оруулалт-ӨНЗ-ын хянаж шалгасан дүгнэлтээс үзэхэд Тосон Уул XIX талбайн нийт ӨНЗ-ын дүн 22.0 сая ам.доллар, үүнээс тухайн жилд өртөгт тосоор нөхөгдсөн дүн 20.3 сая ам.доллар болж, 1.7 сая ам.долларыг үлдэгдлийг хуримтлуулан тооцсон байна.

Харин Тамсаг XXI талбайн нийт ӨНЗ-ын дүн 17.6 сая ам.доллар, үүнээс тухайн жилд өртөгт тосоор нөхөгдсөн дүн 26.4 сая ам.доллар болж, 8.8 сая ам.долларыг тухайн жилийн өртөг зардлаас илүү авсан байна. Энэ нь БХГ-ний 8.2-д "... гарсан өртөг зардлыг нөхөн авах зорилгоор" гэж заасан агуулгыг алдагдуулж, шууд 40 хувь авч байгаа нь БХГ болон холбогдох хуулийн заалтыг зөрчиж байна.

Хуульчийн дүгнэлтээс:¹² Гэрээлэгч газрын тостой холбоотой үйл ажиллагааны явцад гарсан өртөг зардлыг нөхөн авах зорилгоор энэхүү 8.2-ын дагуу хуанлийн сар тутам гэрээт түүхий тос (өртөгт тос) болон гэрээт хийн (40) хувийг авч зарцуулах эрхтэй. Хуанлийн аль ч сард Гэрээлэгчийн авч ашиглах эрхтэй өртөгт тосны дөчин хувь нь энэхүү 8.2-т заасны дагуу тухайн үед нөхөж аваагүй Гэрээлэгчийн нийт зардалтай үнэ өртөгийн хувьд тэнцэх түүхий тосны хэмжээтэй адил байна. Гэхдээ гэрээлэгч нь хуанлийн сар бүрийн гэрээт бүх түүхий тосны нийт хэмжээний (40) хувиас илүү өртөгт тос авах эрхгүй. Түүнчлэн гэрээлэгчийн нөхөж аваагүй үлдсэн бүх өртөг зардал нь дараа дараагийн хуанлийн саруудад бүрэн нөхөж дуустал шилжин тооцогдож байна." Гэрээний энэхүү 8.2-а-гийн зохицуулалттай холбоотой гэрээлэгч өртөг зардлаа авах өртөгт тосыг болон хийг (40) хувиас илүү хэмжээгээр авах эрхтэй эсэх тухай асуудал тавигдаж байна.

Энэ асуудалд хариулахын тулд гэрээ байгуулагдах үед үйлчилж байсан Газрын тосны тухай хуулийн холбогдох заалтыг авч хэрэглэх нь үндэслэлтэй. Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлд /Энэ хуулийн 1991 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр хүчин төгөлдөр үйлчилж эхэлж, 2014 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон байна./ "Гэрээлэгч нь газрын тосыг үр ашигтай олборлож эхэлсэн нөхцөлд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулсан зардлаа нөхөж авах эрхтэй. Зардал нөхөхөд тухайн гэрээлэгчийн жилд олборлосон нийт газрын тосны 40 хүртэл хувийг зарцуулна" гэж зохицуулсан байна.

Улмаар, Гэрээний 8.2-ийн зохицуулалтыг Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлд нийцүүлэн тайлбар хийвэл, Гэрээлэгч өөрийн зардлаа нөхөх зорилгоор нийт тосны болон хийн 40 хүртэл хувийг авах эрхтэй байна. Гэрээнд өртөг зардлаа нөхөх зорилгоор Гэрээлэгч нийт тосны 40 хувиас илүү хувь хэмжээгээр тос авах эрхтэй байхаар зохицуулсан байна гэж үзвэл, энэхүү Гэрээний нөхцөл нь тухайн үед үйлчилж байсан Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийг агуулгын хувьд зөрчсөн байна гэх үндэслэлээр хууль бус байх буюу хүчин төгөлдөр бус байх бүрэн үндэслэлтэй.

Аудитаар ӨНЗ-ын баримт материалыг хянаж үзэхэд дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Гэрээгээр гүйцэтгэх ажил үйлчилгээний зардалд мөнгөөр төлөгдөөгүй төлбөр тооцоог Тосон Уул XIX талбайд 15,416,271.9 ам.доллар, Тамсаг XXI талбайд 25,915,613.2 ам.доллар, нийт 41,331,885.1 ам.доллараар илүү тооцож тусгасан;
- Тайлант оны хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны зардлын төсөвт тусгагдаагүй, төсвийн гүйцэтгэлд АМГГ-аар хяналт хийгдээгүй Тосон Уул XIX талбайд 4,180,855.2 ам.доллар, Тамсаг XXI талбайд 4,456,400.0 ам.доллар, нийт 8,637,255.2 ам.долларыг зарцуулсан;
- Нийгмийн даатгал, татвар төлөөгүй хятад ажиллагсдын цалин, бусад захиргааны зардал Тосон Уул XIX талбайд 18,139,145.5 ам.доллар, Тамсаг XXI талбайд 13,571,059.1 ам.доллар, нийт 31,710,204.6 ам.долларыг ӨНЗ-аар тайлагнасан;
- Тухайн ажил гүйлгээ гарсныг нотлох анхан шатны баримтын бүрдэл дутуу, баримтгүй Тосон Уул XIX талбайд 377,391.0 ам.доллар, Тамсаг XXI талбайд 2,500,437.3 ам.доллар, нийт 2,877,828.3 ам.долларын ажил гүйлгээг бүртгэж тайлагнасан;
- Тосон Уул XIX талбайд 846,056.8 ам.доллар, Тамсаг XXI талбайд 1,055,907.6 ам.доллар, нийт 1,901,964.4 ам.долларын төлсөн татвар хураамж торгууль, төлөөлөгчийн болон сургалт, урамшууллын төлбөр, төрийн болон төрийн бус байгууллагуудад олгосон хандивыг ӨНЗ-д тооцож тайлагнасан;

¹² Хууль зүйн ухааны доктор Б.Тэмүүлэн

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

- *Бараа материалын 2019-2021 оны жилийн эцсийн зарцуулаагүй үлдэгдэл Тосон Уул XIX талбайд 9,665,796.6 ам.доллар, Тамсаг XXI талбайд 9,405,004.9 ам.доллар, нийт 19,070,801.5 ам.долларын материалыг зарцуулснаар ӨНЗ-д тооцож тайлагнасан байна.*

Энэ нь Газрын тосны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон МУЗГ-ын 2019 оны 178 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Газрын тосны бүртгэл тооцооны журмын дараах заалтуудыг тус тус зөрчсөн байна. Үүнд:

- ✓ 2.2.3-д "бараа материал, түүхий эд, химийн болон тэсрэх бодис, сэлбээ хэрэгслийн зардлыг ашиглалтад тавьж олгосон үеэс эхлэн өртөг нөхөгдөх зардалд тооцно",
- ✓ 2.2.6-д "өртөг нөхөгдөх зардал нь анхан шатны баримтаар нотлогдсон байх ба анхан шатны баримт нь ажил, гүйлгээ гарсныг нотлох, бичгээр бүрдүүлсэн гэрээ болон нэхэмжлэх, төлбөрийн даалгавар, орлогын баримт, цагийн тооцоо, акт болон бусад нотлох баримтууд байна",
- ✓ 3.1.2-д "нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийн дагуу бүртгэсэн боловч төлөгдөөгүй аливаа зардал",
- ✓ 3.1.3-д "анхан шатны баримтын бүрдэл дутуу, эсхүл зөрчилтэй, гэрээ болон нэхэмжлэлээс зөрүүтэй нэр, дансаар хийсэн гүйлгээ, холбогдох ажлын төлөвлөгөө, төсвийн дагуу зарцуулагдаагүй, хэтрүүлсэн, эсхүл гэрээнд зөвшөөрөөгүй зардал",
- ✓ 3.1.23-д "гэрээлэгч, эсхүл оператор компанийн газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж байгаа Монгол Улс болон гадаад улс дахь гүйцэтгэх удирдлага, түүнд үйлчлэх үйлчилгээний ажилтнууд, захиргааны ажилтнууд болон захиргааны үйл ажиллагаатай холбогдон гарсан дараах зардал".

Хүснэгт 13. Гэрээлэгчийн тайлагнасан, АМГТГ-ын хянаж дүгнэсэн борлуулалтын орлогын хуваарилалтын тооцоо

/мянган ам.доллар/

Үзүүлэлт	Мөр Дугаар	Нийт 2019-2021 он	
		Гэрээлэгч	АМГТГ
Борлуулсан газрын тосны хэмжээ /мянган баррель/	А	13,872.8	13,956.0
Нэгж үнэ ам.дол /3 жилийн дундаж/	Б	0.2	0.2
Борлуулсан газрын тосны дүн	В	737,008.5	741,708.1
Борлуулалттай холбоотой зардал	Г	83,132.3	82,733.4
Борлуулалтын орлого	Д /В-Г/	653,876.2	658,974.6
ГТНАТ (роялти)	Е /Д*5%, 7.5%/	25,886.0	26,079.9
Өртөгт тос	Ё /Д*40%/	261,550.5	263,589.8
Ашигт газрын тос	Ж /Д-Е-Ё/	366,439.7	369,304.8
МУЗГ-т ногдох газрын тос	З /Ж*40%/	146,575.9	147,721.9
Гэрээлэгчид ногдох газрын тос	И /Ж*60%/	219,863.8	221,582.9
МУЗГ-т ногдох нийт дүн	Й /Е+З/	172,461.9	173,801.9
Гэрээлэгчид ногдох нийт дүн	К /Ё+И/	481,414.3	485,172.7

Эх сурвалж: АМГТГ-ын ирүүлсэн 2019, 2020, 2021 оны дүгнэлт, тайлангаас:

Аудитаар гэрээлэгч газрын тостой холбогдсон бүх үйл ажиллагааг иж бүрэн хамруулсан санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв гаргаагүй, АМГТГ хуулийн дагуу хянан шалгаагүйгээс гадна БХГ зөрчсөн /нийт олборлосон тосноос бус борлуулалтын орлого хуваасан, борлуулалтын орлогоос борлуулалтын зардал хассан, баррель тутмаас 1 ам.доллар хассан, Тосон-Уул XIX талбайд ГТНАТ тооцоогүй, өмнөх аудитаар ГТНАТ-ийг улсын төсөвт төвлөрүүлэх акт хэрэгжээгүй/ зэрэг зөрчлүүд илэрсэн тул

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

газрын тосыг экспортлох үйл ажиллагааг зогсоож, эдгээр асуудлыг нэг мөр шийдвэрлэсний дараа бүтээгдэхүүн хуваалтыг хийх зүйтэй байна.

2.3. АМГТГ нь өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, тогтоосон төлбөрийн актыг биелүүлэх талаар үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүйгээс хэрэгжилт хангалтгүй байна

Өмнөх жилүүдэд гүйцэтгэсэн “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн 2014-2018 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтыг баталгаажуулах” аудитаар өгсөн албан шаардлага, төлбөрийн актын хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 14. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, төлбөрийн актын хэрэгжилт

№	Зөрчлийн товч утга	Шаардсан болон биелэлт ирүүлэх хугацаа	Хариуцах албан тушаалтан	Биелэлтийн хувь хэрэгжүүлсэн арга хэмжээ
1	Тосон Уул XIX, Тамсаг XXI гэрээт талбайн талаар 1993, 1995 онд байгуулсан БХГ-г Газрын тосны тухай хуульд нийцүүлэн шинэчлээгүй байна.	Тосон Уул XIX, Тамсаг XXI гэрээт талбайн БХГг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх; Биелэлтийг 2023.12.15-ны өдрийн дотор ирүүлэх;	УУХҮС Ж.Ганбаатар, АМГТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Баярмандал, “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн ерөнхийлөгч Жу Да Ли	Хэрэгжээгүй. Гэрээний талууд харилцан зөвшилцөлд хүрээгүй, МУЗГ-аас Ажлын хэсэг ажиллаж байна.
2	Газрын тосны борлуулалтын орлогыг дутуу тайлагнасан, борлуулалттай холбогдон гарах зардлыг илүү тооцсон, мөн Тосон Уул XIX талбайд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулаагүй, дутуу тооцож төвлөрүүлсэн байна.	“Петрочайна Дачин Тамсаг ХХК”-аас 30,438,708.94 ам.доллар буюу 66,727,588,846.38 төгрөгийг нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх; Биелэлтийг 2023.12.15-ны өдрийн дотор ирүүлэх;	АМГТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Баярмандал, “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн ерөнхийлөгч Жу Да Ли	Хэрэгжээгүй. АМГТГ төлбөрийн актыг холбогдох дансанд төвлөрүүлэх хугацааны талаар мэдэгдсэн.
3	Газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон гэрээлэгч хооронд газрын тос экспортлох үйл ажиллагааны үед гарах технологийн хорогдлын хэмжээг харилцан тохиролцож баталгаажуулаагүйгээс 2014-2018 онд борлуулсан газрын тосны хэмжээг 175,419.17 баррелиар, борлуулалтын орлогыг 8,298,497.07 ам.доллар буюу 20,791,315,800.15 төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.	Газрын тос экспортлох үйл ажиллагааны үед гарах технологийн хорогдлын хэмжээг бодит тооцоо судалгаанд үндэслэн тогтоож, эрхзүйн актаар баталгаажуулах, хэрэгжилтийг хангах арга хэмжээг авах; Биелэлтийг 2023.05.31-ний өдрийн дотор ирүүлэх;	АМГТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Баярмандал, “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн ерөнхийлөгч Жу Да Ли	Газрын тосны хэмжилт, технологийн хорогдлын хэмжээг 0.5 хувиар харилцан тохирч протокол байгуулсан боловч протокол нь БХГ-г зохицуулах эрх зүйн акт биш байна
4	БХГ-нд Монгол Улсын хууль тогтоомжтой нийцээгүй заалтууд байна.	Газрын тос олборлох үйл ажиллагаанд МУ-ын хууль тогтоомжийг мөрдөх, НДШ болон ХХОАТ-тай холбоотой	АМГТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Баярмандал,	Хэрэгжээгүй. Уг асуудлууд хууль шүүхийн шатанд маргаантай

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

	тооцооллыг дахин хийж, холбогдох байгууллагуудаар баталгаажуулах; Биелэлтийг 2023.05.31-ний өдрийн дотор ирүүлэх;	“Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн ерөнхийлөгч Жу Да Ли	байгаа бөгөөд гэрээний талууд зөвшилцөлд хүрч шийдэгдээгүй байна
--	---	---	--

Аудитын явцад дээрх тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагын талаар хэрэгжүүлсэн арга хэмжээ болон биелэлтийг хянаж үзэхэд хэрэгжилт хангалтгүй холбогдох байгууллагууд тодорхой арга хэмжээ авч ажилласан хэдий ч үр дүнгүй байна.

Мөн холбогдох албан тушаалтнууд аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахгүй байна.

№	Зөвлөмж өгсөн албан тушаалтан	Зөвлөмжийн утга	Хэрэгжсэн эсэх
1	Монгол Улсын Ерөнхий сайдад	Газрын тосны салбарт олборлолтын үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгчийн бүтээгдэхүүн хуваах гэрээний зохицуулалтыг тодорхой болгох зорилгоор хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагад даалган, хэрэгжилтийг хангуулах	МУЕС-ын 2023.05.29-ний өдрийн 96 дугаар захирамж гарч Ажлын хэсэг ажиллаж байна.
2		Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу олборлосон гэрээт түүхий тосыг дотоодын зах зээлд борлуулах, нийлүүлэх талаар эрх зүйн орчныг бүрдүүлэх	Хэрэгжээгүй
3	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад	Гэрээлэгчийн жилийн ажлын төлөвлөгөө, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийг хянах, нэгтгэх тайлагнахтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;	Хэрэгжээгүй
4		Гэрээлэгчийн БХГ-ний дагуу явуулж буй үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагын /гааль, татвар, нийгмийн даатгал, нийгмийн халамж, мэргэжлийн хяналт, орон нутгийн удирдлага гэх мэт/ үйл ажиллагаа хоорондоо хэрхэн уялдаж байгаа талаар болон БХГ-ний хууль тогтоомжийн нийцлийн судалгаа хийж, нийцэлгүй асуудлыг холбогдох байгууллагад танилцуулан шийдвэрлүүлэх арга хэмжээ авч байх	Хэрэгжээгүй
5		Газрын тосны ашиглалтын үеийн үйл ажиллагааны анхдагч мэдээлэл, тайлан, материалыг хүлээн авах, хянах чиг үүргийг холбогдох төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд мэргэжлийн чиглэлээр тодорхой тусгах, бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгох, ажлын гүйцэтгэл, тайлагналд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны хариуцсан нэгж, албан тушаалтнуудын давхар болон дараалсан хяналтын үр дүнг сайжруулах	Хэрэгжээгүй
6	Ашигт малтмал, газрын тосны газрын даргад	Гэрээлэгчийн жилийн болон нэмэлт төлөвлөгөө, төсвийн тооцоолол, түүний үндэслэл, өөрчлөлт оруулах шалтгааныг судалж баримтжуулах, батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу жилийн ажлыг нэгтгэж дүгнэх, өртөг нөхөгдөх зардал болон олборлосон, борлуулсан газрын тосны тайланг сар, улирлаар тасалбар болгон анхан шатны баримттай тулган хянаж, тооцоо нийлэн баталгаажуулан нэгтгэж байх	Хэрэгжээгүй
7		Гэрээлэгчийн тусгай зөвшөөрөлтэй талбайд хийж байгаа газрын тостой холбоотой үйл ажиллагааны баримт бичгийг монгол хэлээр хөтлөх, санхүүгийн тайланд ил тод, нээлттэй, бүрэн тусгаж тайлагнах арга хэмжээг Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлэх	Хэрэгжээгүй

8	Монгол Улсын Засгийн газарт хуваасан газрын тосны орлогыг Газрын тосны газар “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн хооронд харилцан тохиролцсон 2011.06.24-ний өдрийн протоколын дагуу сар бүр тооцоо нийлэн, дараа сарын 25-ны өдрийн дотор төвлөрүүлж байх	Хангалтгүй
9	Газрын тосны салбарт БХГ-ээр үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсөв, түүний дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалт, мөн газрын тосны үйл ажиллагаа явуулахаар бэлтгэсэн материал, эд хөрөнгийн бүртгэл, тооцоог программчилж, нэгдсэн цахим систем бий болгон газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах	Хэрэгжээгүй
10	Газрын тосны ашиглалтын үеийн үйл ажиллагааны анхдагч мэдээлэл, тайлан, материалыг хүлээн авах, хянах чиг үүргийг холбогдох төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд мэргэжлийн чиглэлээр тодорхой тусгах, бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгох, ажлын гүйцэтгэл, тайлагналд тавих хяналтыг сайжруулах	Хангалтгүй

Аудитад хамрагдагч байгууллагаас ирүүлсэн тайлбарыг судалж үзэхэд дараах тодорхойгүй нөхцөл байдал илэрснийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэв.

БХГ-ний 24 зүйлийн 24.1-д “Анхдагч гэрээлэгч болон гүйцэтгэгч бус дараагийн гэрээлэгч нь Монгол Улсын Засгийн газрын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр өөрсдийн эрх үүргийг бүрнээр буюу аль нэг хэсгийг бусдад шилжүүлж болохгүй” гэж заасан боловч 2005 онд анхны гэрээлэгчээс хувьцаа худалдан авах замаар “Дачин Ойлфийлд” ХХК-ийн эрх шилжүүлэх тухай Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар, өмнөх гэрээлэгч хооронд бүх эрх үүргийг шилжүүлэх тохиролцоо хийсэн байна. Уг тохиролцоо нь:

1. Монгол Улсын Засгийн газраас бичгээр өгсөн зөвшөөрөлгүй бөгөөд
2. Шилжүүлэх эрхийг БНХАУ-ын “Дачин Ойлфийлд” ХХК хүлээн авч,
 - БХГ-ХІХ талбайн эзэмших эрхийг Дачин 94.443 %
Петровьетнам 5 %
Блам 0.56 %
 - БХГ-ХХІ талбайн эзэмших эрхийг Дачин 94.444 %
Петровьетнам 5 %
Блам 0.56 %
 - БХГ-ХХІІ талбайн эзэмших эрхийг Дачин 94.443 %
Петровьетнам 5 %
Блам 0.557 %

гэж тус тус зөвшөөрсөн байна. Гэтэл “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-аас 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 23/5-1679 дугаар албан бичгээр ирүүлсэн тайлбартаа:

1. Петрочайна Дачин Тамсаг Монгол (ХІХ) ХХК

2. Петрочайна Дачин Тамсаг Монгол (XXI) ХХК

3. Петрочайна Дачин Тамсаг ХХК гурван компани байгаагаас 19, 21-р талбайн компаниудын бүртгэлтэй газар нь Их Британийн Каймань арал ба Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн бүртгэлтэй газар нь Монгол Улсын Улаанбаатар хот юм. Петрочайна Дачин Тамсаг ХХК нь Петрочайна Дачин Тамсаг Монгол (XIX) ХХК, Петрочайна Дачин Тамсаг Монгол (XXI) ХХК-ийн толгой компани биш гэж тайлбарласан.

Мөн хуучнаар ГТГ-ын даргын 2010 оны 18, 2011 оны 111 дүгээр тушаалын 1-д Тосон Уул XIX талбайд үйлдвэрлэлийн олборлолт явуулж эхлэхийг АНУ-ын Делавер хотод бүртгэлтэй Петрочайна Дачин Тамсаг компанийн 100 хувийн хөрөнгө оруулалттай БХГ-ний гэрээлэгч Петрочайна Дачин Тамсаг Монгол (XIX) компани, 2012 оны 207 дугаар тушаалын 1-д Тамсаг XXI талбайд газрын тосны ашиглалт явуулж эхлэхийг АНУ-ын Делавер хотод бүртгэлтэй Петрочайна Дачин Тамсаг компанийн 100 хувийн хөрөнгө оруулалттай БХГ-ний гэрээлэгч Петрочайна Дачин Тамсаг Монгол компанид зөвшөөрсөн нь компанийн нэр зөрүүтэй, БХГ-ний гэрээлэгч хэн болох нь тодорхойгүй байна.

Энэ талаар өмнөх аудитаар Монгол Улсын Ерөнхий сайдад гэрээлэгчийн БХГ-ний зохицуулалтыг тодорхой болгох холбогдох төрийн захиргааны төв байгууллагад даалган, хэрэгжилтийг хангуулах зөвлөмж өгсөн боловч хэрэгжээгүй байна.

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

Шалгагдагч байгууллагаас ирүүлсэн хариу



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР

Засгийн газрын XII байрны баруун жигүүр,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 26 38 26, Факс: (976-11) 31 03 70,
Цахим шуудан: info@mrpam.gov.mn,
Цахим хуудас: mrpam.gov.mn

2023.12.11 № 1/5846
танай 2023.12.01-ны № 06/2463 -т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Танай 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 06/2463 дугаартай албан бичгээр ирүүлсэн "Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх" аудитын тайлангийн төслийн дүгнэлт, зөвлөмжид холбогдох санал, тайлбарыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 3 хуудастай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРДОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Д.БАЯРМАНДАЛ



53754721

Ашигт малтмал газрын тосны газрын
2023 оны 11 дугаар сарын 11-ны өдрийн
1/5846 дугаар албан бичгийн хавсралт



Аудитын тайлангийн төсөл дэх дүгнэлт, зөвлөмжид өгөх тайлбар, санал

Дүгнэлтийн 1-т:

Газрын тосны тухай хуулийн 4.1.24-д "үр ашигтай нээлт" гэж тухайн үеийн техник, технологийн түвшинд ашиглахад эдийн засгийн үр ашигтай газрын тосны хуримтлал бүхий хураагуурыг", харин Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайн бүтээгдэхүүний хуваах гэрээний 2 дугаар зүйлд "Үр ашигтай нээлт" гэдэг нь гэрээлэгчийн тооцоолсон олборлох нөөц, газрын тосны үнэ, олборлолтын зардал зэргийг оролцуулсан техник-эдийн засгийн зохих хүчин зүйлсийг харгалзан үр ашигтайгаар олборлох боломжтой гэж гэрээлэгчийн тогтоосон нэг эсвэл хоёр (2) түүнээс дээш тооны байгалийн агууламжийг хэлнэ." гэж заасан байдаг. Иймд үр ашигтай нээлт байхын тулд олборлох нөөц, газрын тосны үнэ, олборлолтын зардал зэрэг нь тодорхой, техник эдийн засгийн үндэслэлээр тус ордыг ашиглах нь эдийн засгийн үр ашигтай гэсэн дүгнэлт гарсан байх шаардлагатай. Петрочайна дачин тамсаг ХХК нь Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайн бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх үүргийг 2005 онд шилжүүлэн авч, газрын тосны хайгуулыг эрчимтэй хийсний үр дүн 2010-2012 онуудад Тосон-Уул орд, Тамсагийн ордын нөөцийн тооцооны тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн газрын тосны нөөцийг батлуулсан. Тосон-Уул орд нь газрын тосны хуримтлал бүхий 45 ширхэг байгалийн агууламж, Тамсаг орд нь газрын тосны хуримтлал бүхий 13 ширхэг байгалийн агууламжаас тус тус бүрдсэн хураагуур болно. Тус батлуулсан нөөцийн үндсэн дээр Газрын тосны ордыг ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан Газрын тосны газрын (хуучнаар) Техникийн зөвлөлөөр хэлэлцүүлж, тус ордуудыг ашиглах нь эдийн засгийн үр ашигтай гэсэн дүгнэлтийн хүрээнд орд ашиглах төлөвлөгөөг 2012 оны 08 дугаар сарын 15-ны өдөр батлуулсан. Газрын тосны ордыг ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд газрын тосны үнэ, олборлолтын зардал зэрэг нь тодорхой тусгагдсан болно. Иймд Тосон-Уул, Тамсагийн газрын тосны ордын үр ашигтай нээлтийг 2012 онд тодорхойлсон гэж ойлгож болно.

Дүгнэлтийн 2-т:

Тосон-Уул, Тамсагийн ордын газрын тосны нөөц батлагдаж, ордыг ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр тус ордуудыг ашиглах нь эдийн засгийн үр ашигтай болох нь тогтоогдож, Газрын тосны тухай хуулийн (БНМАУ-ын 1991 оны) 7.1-д заасны дагуу газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад зориулсан эдэлбэр газрын зөвшөөрлийг Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн 154 тогтоолоор олгосон. Мөн Бүтээгдэхүүн хуваах гэрээний 5.6 "Хайгуулын хугацаа аяндаа дууссан буюу түүнийг бусад хэлбэрээр зогсоосон эсэхийг үл харгалзан энэ гэрээ үр ашигтай нээлт нэг бүрийн хувьд, тухайн үр

ашигтай нээлтийг бүртгэсэн өдрөөс хойш 20 жилийн хугацаа (олборлолтын хугацаа)-нд хүчин төгөлдөр хэвээр байна." гэж заасны дагуу үр ашигтай нээлт болох нь тогтоогдсон 2012 оноос эхлэн олборлолтын хугацааг (ашиглалтын хугацаа) тооцно.

Дүгнэлтийн 3-т:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-т "Санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ", 17.1.7-т "...Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт мөрдөх үүрэгтэй аж ахуйн нэгж, байгууллага энэхүү стандартыг хэрхэн мөрдөж байгаад харилцагч санхүүгийн байгууллагатай хамтран хяналт тавих", Сангийн сайдын 2020 оны 46 дугаар тушаалын хавсралт "Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланг хүлээн авах, хянах, нэгтгэл хийх, нэгтгэлийн мэдээллийг ашиглах журам"-ын 3.3-т "Санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай харьцдаг дараах аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайланг цахим хэлбэрээр болон батлагдсан маягтын дагуу биечлэн тушаах ба Сангийн яамны тухайн чиглэлийн асуудлыг хариуцаж буй газраар хянуулсны үндсэн дээр хүлээн авна.", 3.3.2-т "Засгийн газартай бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан" гэж заасны дагуу Сангийн яам чиг үүргийнхээ дагуу хянадаг.

Дүгнэлтийн 7-д:

Өмнөх аудитаар өгсөн албан албан шаардлага, тогтоосон төлбөрийн акт, зөвлөмжийн талаар хэрэгжүүлсэн арга хэмжээ, биелэлтийг тухай бүр ҮАГ-т хүргүүлэн ажиллаж байна. Мөн цаашид холбогдох арга хэмжээг авч ажиллах болно.

Зөвлөмжийн 3-т

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-т "Санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ", 17.1.7-т "...Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт мөрдөх үүрэгтэй аж ахуйн нэгж, байгууллага энэхүү стандартыг хэрхэн мөрдөж байгаад харилцагч санхүүгийн байгууллагатай хамтран хяналт тавих", Сангийн сайдын 2020 оны 46 дугаар тушаалын хавсралт "Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланг хүлээн авах, хянах, нэгтгэл хийх, нэгтгэлийн мэдээллийг ашиглах журам"-ын 3.3-т "Санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай харьцдаг дараах аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайланг цахим хэлбэрээр болон батлагдсан маягтын дагуу биечлэн тушаах ба Сангийн яамны тухайн чиглэлийн асуудлыг хариуцаж буй газраар хянуулсны үндсэн дээр хүлээн авна.", 3.3.2-т "Засгийн газартай бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан" гэж заасны дагуу Сангийн яам чиг үүргийнхээ дагуу хянадаг.

Зөвлөмжийн 5-д

Тосон-Уул, Тамсагийн ордын газрын тосны нөөц батлагдаж, ордыг ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр тус ордуудыг ашиглах нь эдийн засгийн үр ашигтай болох нь тогтоогдож, Газрын тосны тухай хуулийн (БНМАУ-ын 1991 оны) 7.1-д заасны дагуу газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад зориулсан эдэлбэр газрын зөвшөөрлийг Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн 154 тогтоолоор олгосон. Мөн Бүтээгдэхүүн хуваах гэрээний 5.6

"Хайгуулын хугацаа аяндаа дууссан буюу түүнийг бусад хэлбэрээр зогсоосон эсэхийг үл харгалзан энэ гэрээ үр ашигтай нээлт нэг бүрийн хувьд, тухайн үр ашигтай нээлтийг бүртгэсэн өдрөөс хойш 20 жилийн хугацаа (олборлолтын хугацаа)-нд хүчин төгөлдөр хэвээр байна." гэж заасны дагуу үр ашигтай нээлт болох нь тогтоогдсон 2012 оноос эхлэн олборлолтын хугацааг (ашиглалтын хугацаа) тооцно.

Зөвлөмжийн 1, 2, 7-д

Манай газар аудитаар өгсөн зөвлөмжийн талаар арга хэмжээ авч ажиллан, биелэлтийг тухай бүр ҮАГ-т хүргүүлэн ажиллаж байна.

Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн Тосон Уул XIX болон Тамсаг ХХI гэрээт талбайн талаар 1993, 1995 онд байгуулсан БХГ-г Газрын тосны тухай хуульд нийцүүлэн шинэчлэх асуудлаар өнгөрсөн хугацаанд ажлын хэсгүүд байгуулагдан ажилласан байдаг. 2023 оны тухайд: Засгийн газрын 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны 21 дүгээр тэмдэглэлд "Бүтээгдэхүүн хуваах гэрээг дүгнэх, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх асуудлыг судалж, санал боловсруулах арга хэмжээ авч ажиллах"-ыг Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгаланд даалгасан. Үүний дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/199 дугаар тушаалаар байгуулагдсан "Ажлын хэсгийг мэдээллээр хангах үүрэг бүхий" дэд ажлын хэсэг Тосон-Уул XIX, Тамсаг ХХI талбайд байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилт, хөрөнгө оруулалт, борлуулалтын орлого, бүтээгдэхүүн хуваалтын байдалд дүн шинжилгээ хийж, төслийн үр ашгийг тооцоолж, дүгнэлтээ ажлын хэсэгт танилцуулсан. БХГ-г шинэчлэх ажлын талаарх мэдээллийг АМГТГ-ын 2023 оны 11 дүгээр сарын 3/5552 дугаар албан бичгээр ҮАГ-т хүргүүлсэн.

Иймд дээрх тайлбар үндэслэл, саналыг аудитын дүгнэлт, зөвлөмжид тусгаж өгөхийг хүсье.

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР

Шалгагдагч АМГТГ-ын санал, авсан арга хэмжээ

№	АМГТГ-аас ирүүлсэн санал, тайлбар	ҮАГ-ын хариу тайлбар
1	<p>Дүгнэлтийн 1-т: “Петрочайна Дачин Тамсаг” ХХК нь Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайн бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх үүргийг 2005 онд шилжүүлэн авч, газрын тосны хайгуулыг эрчимтэй хийсний үр дүн 2010-2012 онуудад Тосон Уул орд, Тамсагийн ордын нөөцийн тооцооны тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн газрын тосны нөөцийг батлуулсан. Тосон Уул орд нь газрын тосны хуримтлал бүхий 45 ширхэг байгалийн агууламж, Тамсаг орд нь газрын тосны хуримтлал бүхий 13 ширхэг байгалийн агууламжаас тус тус бүрдсэн хураагуур болно. Тус батлуулсан нөөцийн үндсэн дээр Газрын тосны ордыг ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан Газрын тосны газрын (хуучнаар) Техникийн зөвлөлөөр хэлэлцүүлж, тус ордуудыг ашиглах нь эдийн засгийн үр ашигтай гэсэн дүгнэлтийн хүрээнд орд ашиглах төлөвлөгөөг 2012 оны 08 дугаар сарын 15-ны өдөр батлуулсан. Газрын тосны ордыг ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд газрын тосны үнэ, олборлолтын зардал зэрэг нь тодорхой тусгагдсан болно. Иймд Тосон Уул, Тамсагийн газрын тосны ордын үр ашигтай нээлтийг 2012 онд тодорхойлсон гэж ойлгож болно.</p>	<p>Аудитын явцад энэхүү тайлбар мэдээллийг авч үнэлсэн бөгөөд энэхүү тайлбар нь БХГ-ний 4, 5 дугаар зүйлийг зөрчих үндэслэл болж байна. Үүнд: “Үр ашигтай нээлт” гэж гэрээлэгчийн тооцоолсон олборлох нөөц, газрын тосны үнэ, олборлолтын зардал зэргийг оролцуулсан техник, эдийн засгийн зохих хүчин зүйлсийг харгалзан үр ашигтайгаар олборлох боломжтой гэж үзсэн гэрээлэгчийн тогтоосон нэг эсвэл хоёр түүнээс дээш тооны байгалийн агууламжийг хэлнэ гэж зааснаас үзвэл: ✓ Гэрээлэгч өөрөө тооцоолсон /алдагдалтай бол өөрөө хариуцах/ ✓ Гэрээлэгч тогтоосон /Эрсдэлээ хариуцах зарчмын дагуу зардлаа бууруулж, үр ашигтай ажиллах эрмэлзэхээ баталгаажуулах нэг хэлбэр/ Түүнчлэн БХГ-ний дагуу гэрээлэгчээс зайлшгүй хийсэн байх дээрх үйлдлүүдийн нотлох баримт байхгүй тул тайлбарыг хүлээж авах боломжгүй байна. /Дэлгэрэнгүйг хуудас 6-10/</p>
2	<p>Дүгнэлтийн 2-т Тосон Уул, Тамсагийн ордын газрын тосны нөөц батлагдаж, ордыг ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр тус ордуудыг ашиглах нь эдийн засгийн үр ашигтай болох нь тогтоогдож, Газрын тосны тухай хуулийн (БНМАУ-ын 1991 оны) 7.1-д заасны дагуу газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад зориулсан эдэлбэр газрын зөвшөөрлийг Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн 154 тогтоолоор олгосон. Мөн Бүтээгдэхүүн хуваах гэрээний 5.6-д “Хайгуулын хугацаа аяндаа дууссан буюу түүнийг бусад хэлбэрээр зогсоосон эсэхийг үл харгалзан энэ гэрээ үр ашигтай нээлт нэг бүрийн хувьд, тухайн үр ашигтай нээлтийг бүртгэсэн өдрөөс хойш 20 жилийн хугацаа (олборлолтын хугацаа)-нд хүчин төгөлдөр хэвээр байна” гэж заасны дагуу үр ашигтай нээлт болох нь тогтоогдсон 2012 оноос эхлэн олборлолтын хугацааг (ашиглалтын хугацаа) тооцно.</p>	<p>БХГ-ний 5 дугаар зүйлд хугацааг Гэрээлэгч үр ашигтай нээлт нэг бүрийн хувьд мэдэгдсэн буюу бүртгэгдсэн өдрөөс эхлэн 20 жил байхаар тодорхой заасан. Гэтэл Газрын тосны тухай хуулийн (БНМАУ-ын 1991 оны) 7.1-д “Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад зориулан эдэлбэр газрын зөвшөөрлийг орон нутгийн эрх барих байгууллага, ...” гэж заасан байхад Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн 154 тогтоолоор эдэлбэр газрын зөвшөөрлийг олгосон нь хуультай нийцэхгүй байх бөгөөд хуулийн байгууллагаар шалгуулах асуудалд хамаарч байна. /Дэлгэрэнгүйг хуудас 10-11/</p>
3	<p>Дүгнэлтийн 3-т: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-т "Санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ", 17.1.7-т "...Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт мөрдөх үүрэгтэй аж ахуйн нэгж, байгууллага энэхүү стандартыг хэрхэн мөрдөж байгаад харилцагч санхүүгийн байгууллагатай хамтран хяналт тавих", Сангийн сайдын 2020 оны 46 дугаар тушаалын хавсралт “Аж ахуйн</p>	<p>Энэ заалтын хүрээнд СЯ-д зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн бөгөөд АМГТГ нь гэрээлэгчийн тайлагнасан ӨНЗ-ын гүйцэтгэлийг хянаж, дүгнэлт ирүүлэхдээ санхүүгийн тайланг хянаагүй Газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д заасан үүргээ хэрэгжүүлээгүй тул холбогдох албан тушаалтанд сахилгын хариуцлага ноогдуулах албан шаардлага тус тус</p>

	<p>нэгж, байгууллагын санхүүгийн тайланг хүлээн авах, хянах, нэгтгэл хийх, нэгтгэлийн мэдээллийг ашиглах журам"-ын 3.3-т "Санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай харьцдаг дараах аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайланг цахим хэлбэрээр болон батлагдсан маягын дагуу биечлэн тушаах ба Сангийн яамны тухайн чиглэлийн асуудлыг хариуцаж буй газраар хянуулсны үндсэн дээр хүлээн авна", 3.3.2-т "Засгийн газартай бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан" гэж заасны дагуу Сангийн яам чиг үүргийнхээ дагуу хянадаг.</p>	<p>хүргүүлж байгаа болно. /Дэлгэрэнгүйг хуудас 11-13/ Цаашид хяналт шалгалтыг хийхдээ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6-д заасны дагуу харилцагч санхүүгийн байгууллагын баталгаажуулсан цахим санхүүгийн тайланд үндэслэн холбогдох байгууллага татвар, шимтгэл, хураамжийн тооцоо хийхээс гадна төрийн эрх бүхий байгууллага нь энэхүү цахим санд баталгаажсан аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан, тодруулгыг ашиглах тухай зөвлөмж өгөв.</p>
4	<p><u>Дүгнэлтийн 7-д:</u> Өмнөх аудитаар өгсөн албан албан шаардлага, тогтоосон төлбөрийн акт, зөвлөмжийн талаар хэрэгжүүлсэн арга хэмжээ, биелэлтийг тухай бүр УАГ-т хүргүүлэн ажиллаж байна. Мөн цаашид холбогдох арга хэмжээг авч ажиллах болно.</p>	<p>Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, тогтоосон төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлж тайланд тусгасан. /Дэлгэрэнгүйг хуудас 21-23/</p>

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас ирүүлсэн хариу



МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД

Засгийн газрын II байр, Нэгдсэн үндэстний гудамж 5/1,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 35 06, Факс: (976-11) 31 13 81,
Цахим хуудас: www.mmhi.gov.mn

2023.12.21 № 01/3066
танай 2023.12.06 -ны № 01/2494 -Т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Танай 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 01/2494 дүгээр албан бичгээр ирүүлсэн "Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх" аудитын тайлангийн төсөлтэй танилцаж, тайлбарыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 4 хуудастай.



Ж.ГАНБААТАР

1568 35 1386

ГАЗРЫН ТОСНЫ САЛБАРТ БХГ-ЭЭР ОЛБОРЛОЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ГЭРЭЭЛЭГЧИЙН НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ӨРТӨГ НӨХӨГДСӨН БОЛОН НӨХӨГДӨХ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ, ГАЗРЫН ТОСНЫ ЭКСПОРТ, БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН ТООЦОО, ХУВААРИЛЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТАД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАНД ӨГӨХ ТАЙЛБАР, САНАЛ:

1.1 Төсөл нь эдийн засгийн хувьд үр ашиггүй байхад гэрээлэгч өртөг зардал нөхөж авч байгаа нь БХГ-нд нийцэхгүй байна.

БХГ ний үндсэн зарчим нь газрын тосны хайгуулын талбай нь өмнө нь судлагдаагүй тодорхойгүй нөхцөлд буюу газрын тосны хайгуул, судалгааны ажил хийгдээгүй, газрын тосны илрэл, нөөц тогтоогдоогүй талбайд Гэрээлэгч эрсдэлээ өөрөө хариуцан гэрээ байгуулж газрын тостой холбогдсон үйл ажиллагааг эхлүүлэн явуулдаг онцлогтой. Нэгэнт хайгуулын үе шат дуусаад үр ашигтай нээлтийг бүртгэж, нөөцийг батлагдсаны дараа ашиглалтад шинжсэн үед үр ашигтай нээлтийн талаар яригдахгүй болно. Гэрээлэгч гаргасан зардлынхаа тодорхой хувийг гэрээнд тохиролцсоны дагуу өртөг нөхөх зардалд авах нь уг гэрээний нэг үндсэн нөхцөл буюу хөрөнгө оруулалт хийх цаашид уг төслийг үргэлжлүүлэн гүйцэтгэх гол хөшүүрэг болдог онцлогтой.

Газрын тосны газрын /хуучин нэрээр/ даргын 2011 оны 111 дүгээр тушаалаар Тосон Уул-ХИХ талбайд, 2012 оны 207 дугаар тушаалаар Тамсаг-ХХI талбайд үр ашигтай нээлт зарлаж ашиглалтын үйл ажиллагаа явуулж эхлэхийг зөвшөөрсөн тушаалыг тус тус гаргасан байдаг.

Иймд БХГ-ний дагуу тухайн жилд олборлосон газрын тосны 40 хувийг өртөг нөхөх зардалд авах асуудал нь гэрээнд тусгагдсан үндсэн нөхцөлийн дагуу авч буй хувь хэмжээ бөгөөд тухайн төслийн хувьд Гэрээлэгч гаргасан зардлаа бүрэн нөхөх хүртэл олборлолт экспортын үйл ажиллагаа явуулж буй тохиолдолд авах зохицуулалттай болно.

Газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй Тосон-Уул-19, Тамсаг-21 талбайн БХГ-г хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх талаар 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 96 дугаар бүхий Ерөнхий сайдын захирамж гарч Ажлын хэсэг ажиллаж байна.

Уг Ажлын хэсэг хуралдаж гишүүдэд хариуцсан асуудлуудаар санал боловсруулж нэгтгэх үүрэг даалгаврыг өгч ажилласан. МУ-ын сайд ЗГХЭГ-ын даргаар ахлуулсан Ажлын хэсэг БНХАУ-ын Бээжин хотод Хятадын газрын тосны корпорацын удирдлагуудтай бүтээгдэхүүн хуваах гэрээг шинэчлэх талаар ажлын уулзалт хийсэн ба Хятадын талаас мөн Ажлын хэсэг гаргаж хамтран ажиллах талаар санал солилцсон.

1.2. Тосон Уул-ХИХ талбайн ӨНЗ-ыг 1996 оноос өртөг зардлыг нөхөж авснаар үр ашигтай нээлт бүртгэгдсэн гэж тооцвол БХГ-ний хүчин төгөлдөр хугацаа дууссан.

АМГТГ-аас БХГ-ний хугацаа болон олборлолт эхэлсэн талаарх мэдээлэл, нотлох баримтыг бүрэн гаргаж өгөх ёстой.

Газрын тосны газрын /хуучин нэрээр/ даргын 2011 оны 111 дүгээр тушаалаар Тосон Уул-ХИХ талбайд, 2012 оны 207 дугаар тушаалаар Тамсаг-ХХИ талбайд үр ашигтай нээлт зарлаж ашиглалтын үйл ажиллагаа явуулж эхлэхийг зөвшөөрсөн тушаалыг тус тус гаргасан байдаг ба энэхүү тушаалд дурдсан хугацаагаар газрын тосны ашиглалтын хугацааг тоолж эхэлдэг. /Газрын тосны газрын даргын тушаалуудыг хавсаргав./

1.3 “Петрочайна Дачин Тамсаг” ХХК газрын тостой холбогдсон бүх үйл ажиллагаанд хамаарах ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд иж бүрэн, үнэн зөв тайлагнаагүй, түүнийг хянах байгуулагууд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй байна.

Уг асуудалд тусгагдсан санхүүгийн тайлан материал дутуу байх, тооцоо нийлсэн акт, гэрээ дүгнэсэн актуудыг ирүүлээгүй зэрэг зөрчил дутагдал гарсан нь зарим баримт материал БНХАУ-д буюу толгой компанид байх магадлалтай бөгөөд сүүлийн жилүүдэд анхдагч баримт материалыг газар дээр нь очиж бүртгэж баримтжуулаагүйтэй холбоотой байх магадлалтай.

Иймд дээрх албан шаардлагыг хүлээн авах боломжтой гэж үзлээ.

2.1 АМГТГ-ын дүгнэлт, тайлан хуулийн шаардлага хангахгүй байна.

Тосон Уул-ХИХ талбайн БХГ-ний хувьд газрын тосны нөөц ашигласны төлбөр буюу рояалти нь БХГ-ний 8.1.-д “Бүтээгдэхүүний аливаа төлбөр нь ашигт тосны монголын ногдол хэсэгт багтах бөгөөд түүнийг МГТ компани Монголын Засгийн газарт төлнө.” гэж заасан байдаг тул рояалти-г тусад нь 5 хувиар тооцох боломжгүй. Энэ асуудлаар БХГ-г хууль тогтоомжуудад нийцүүлэн шинэчлэх талаар Ажлын хэсэг ажиллаж байна.

Газрын тосны дэлхийн зах зээлийн үнэ өндөр байх тохиолдолд өртөг нөхөх зардлыг богино хугацаанд нөхөх боломжтой байдаг болно.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

ҮАГ-ын хариу тайлбар :

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас ирүүлсэн тайлбар нь шалгагдагч болон хамрагдагч этгээдүүдийн ирүүлсэн санал тайлбартай агуулгын хувьд давхцаж байгаа тул тайланд нэмэлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

Аудитад хамрагдагч байгууллагаас ирүүлсэн тайлбар, санал



ҮНДЭСНИЙ АУДИТЫН
ГАЗАРТ

ПЕТРОЧАЙНА ДАЧИН ТАМСАГ ХХК

14201 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 6-р хороо,
Бага тойруу гудамж, Могол Тэвэр 4 давхар,
Утас: (976)-7710-2777, Факс (976)-7712-2777,
И-мэйл: pdtmdatamo@gmail.com

2023.12.13 № 23/5-1079
танай _____ № _____

Манай компани Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 1996 оны 8 тоот зөвлөмж, МУЗГ-ын 1993 оны 07 сарын 23-ны өдрийн 253, 1996 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 183 тоот, 1996 оны 08 дугаар сарын 09-ны өдрийн 144 дүгээр тогтоолуудаар тус тус батламжилсан БХГ-ний гэрээлэгч тал юм. Манай компани Бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээлэгчийн хувьд Засгийн газраас батламжилсан БХГ-г баримтлан Тамсагийн төслийг явуулж байна.

Үндэсний аудитын газрын 06/2464 тоот албан бичгийн тухайд дараах хариуг хүргүүлж байна. Үүнд:

Аудитын газрын санал:

Нэг. Газрын тосны нийт орлого 8.5 их наяд, нийт зардал 11.4 их наяд, алдагдал 2.9 их наяд төгрөг байхад техник эдийн засгийн хувьд үр ашигтай гэж үзэн өртөг нөхөгдөх зардлыг нөхөж авч байгаа нь БХГ-г зөрчиж байна.

(1) Төсөл эдийн засгийн хувьд үр ашиггүй байхад гүйцэтгэгч зардлаа нөхөж байгаа нь БХГ-нд нийцэхгүй байна.

(2) 1996 оноос эхлэн Тосон-Уул 19 дүгээр талбайн өртгийг нөхөж үр ашигтай нээлт бүртгэсэн гэж үзвэл БХГ-ний хүчинтэй хугацаа дууссан.

(3) Петрочайна Дачин Тамсаг компани нь нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайландаа газрын тостой холбоотой бүх үйл ажиллагааны гүйлгээг бүрэн, үнэн зөв тайлагнаагүй бөгөөд түүнд хяналт тавих байгууллагууд ч хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй.

Манай компанийн санал:

1. Petrochina Daqing Tamsag Mongolia (XIX) Ltd - Петрочайна Дачин Тамсаг Монгол (XIX) ХХК
Petrochina Daqing Tamsag Mongolia (XXI) Ltd - Петрочайна Дачин Тамсаг Монгол (XXI) ХХК
Petrochina Daqing Tamsag Ltd - Петрочайна Дачин Тамсаг ХХК

19, 21-р талбайн компаниудын бүртгэлтэй газар нь Их Британийн Каймань арал

ба Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн бүртгэлтэй газар нь Монгол Улсын Улаанбаатар хот юм. Петрочайна Дачин Тамсаг ХХК нь Петрочайна Дачин Тамсаг Монгол (XIX), Петрочайна Дачин Тамсаг Монгол (XXI) ХХК-ийн толгой компани биш бөгөөд дээрх гурван компани нь өөр өөр хуулийн субъект, нягтлан бодох бүртгэлийн субъект юм. 19, 21-р талбайн компаниудын санхүүгийн мэдээллийг Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн санхүүгийн тайланд нэгтгэвэл Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн санхүүгийн тайлангийн мэдээллийг гажуудуулж, санхүүгийн баланс болон тайлан зөрүүтэй гарах тул нэгдэх нөхцөл хангагдахгүй.

Санал: Сангийн яамнаас гаргасан санхүүгийн тайлангийн загварт үндэслэн цаасан хэлбэрээр нэгтгэсэн тайлан гаргаж, дээрх гурван компанийн санхүүгийн мэдээллийг тусгаснаар Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн данс тайлантай тохирч, мэдээлэл үнэн зөв байх боломжтой ба нөгөө талаас Монгол Улсын засгийн газрын байгууллагуудад тайлагнасан санхүүгийн мэдээлэлтэй адил байх баталгаа болох юм.

2. БХГ-ний тодорхойлолт хэсэгт "Үр ашигтай нээлт" гэдэг нь гэрээлэгчийн тооцоолсон олборлох нөөц, газрын тосны үнэ, олборлолтын зардал зэргийг оролцуулсан техник-эдийн засгийн зохих хүчин зүйлсийг харгалзан үр ашигтайгаар олборлох боломжтой гэж гэрээлэгчийн тогтоосон нэг эсвэл хоёр (2) түүнээс дээш тооны байгалийн агууламжийг хэлнэ" гэж заасан байдаг. БХГ-ний ARTICLE II DEFINATIONS хэсгийн "COMMERCIAL DISCOVERY" means a reservoir or a group of two (2) or more reservoirs containing Petroleum which the Contractor determines to be worthy of being developed commercially, taking into consideration relevant technical and economic factors, including Contractor's estimates of recoverable reserves, prices of Petroleum and cost of development. Аудитын зүгээс уг тодорхойлолтыг зөвхөн эдийн засгийн үр ашиг талаас нь үнэлж дүгнэж байгаа нь өрөөсгөл бөгөөд гэрээний дээрх агуулгатай зөрчилдөж байгаа болно.

Үр ашигтай нээлт ба төслийн эдийн засгийн ерөнхий үр ашиг нь ижил ойлголт биш юм. Үр ашигтай нээлт гэдэг нь хайгуулын үеийн ойлголт ба хайгуулын хугацаанд тосны цооногуудад дүн шинжилгээ хийж, тодорхойлон улмаар тос олборлох боломжтой бөгөөд өртөг зардлаа нөхөх боломжтой гэж гэрээлэгчийн байгалийн агууламжийг хэлнэ. Төслийн нийт эдийн засгийн үр ашиг гэдэг нь төслийн бүх хугацааны орлого зарлагын тэнцлийг хэлнэ.

Хугацааны дарааллын хувьд эхлээд өрөмдлөгийн үйл ажиллагаа явуулж, тосны цооноогоос газрын тос гарсны дараа гүйцэтгэгч болон Засгийн газрын байгууллага үр ашигтай нээлт мөн эсэхийг үнэлж, баталгаажуулдаг. Хэрэв үр ашигтай нээлт болохыг баталгаажуулбал олборлолтын үе шатанд орж, газрын тосны үйл ажиллагаанд оруулсан бүх хөрөнгө оруулалтыг нөхөж авдаг. Хайгуулын хугацаанд ямар нэгэн үр ашигтай нээлт илрүүлээгүй тохиолдолд гүйцэтгэгч компанийн хөрөнгө оруулалт үр ашиггүй болж, орлого байхгүй тул нөхөж авах боломжгүй болно. Түүнчлэн БХГ-ний 25.4 заасанчлан уг гэрээ нь Англи болон Монгол хэл дээр үйлдэгдэх ба аливаа маргаан гарсан тохиолдолд Англи хэл дээрх хувилбар нь давуу эрхтэй гэж заасанчлан БХГ-ний 2 дугаар зүйлд Үр ашигтай нээлт гэж тодорхойлсон тодорхойлолтын Монгол хэл дээрх орчуулга нь агуулгын хувьд зөрүүтэй ойлголт төрүүлэхүйц байгааг дурьдах нь зүйтэй.

3. 2004 оны 1-р сарын 31-нд SOCO болон ГТГ (Гарын үсэг зурсан хүн О.Даваасамбуу) хооронд хайгуулын хугацааг сунгах баримт бичигт гарын үсэг зурсан ба үүнд нь SOCO International компанийн эзэмшиж буй 19, 21, 22-р талбай болон Dongshen Jinggong Petroleum Development Group-т хамаарах талбайн хугацааг сунгасан. Энэхүү баримт бичиг нь ГТГ болон SOCO компанийн хооронд

байгуулагдсан ба худалдан авах үед шилжүүлэн өгөөгүй тул Газрын тосны газар эсвэл Үндэсний архиваас лавлах шаардлагатай. БХГ-нд заасан газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа нь хайгуулын хугацаа, ашиглалтын хугацаа гэсэн хоёр үе шаттай. Манай компани болон Монгол Газрын тос компанийн байгуулсан БХГ-ний 5.5-р зүйл Олборлолтын хугацаа хэсэгт "Хайгуулын хугацаа аяндаа дууссан буюу түүнийг бусад хэлбэрээр зогсоосон эсэхийг үл харгалзан энэ гэрээ үр ашигтай нээлт нэг бүрийн хувьд, тухайн үр ашигтай нээлтийг бүртгэсэн өдрөөс хойш 20 жилийн хугацаа (олборлолтын хугацаа)-нд хүчин төгөлдөр хэвээр байна" гэж заасан. Иймд ашиглалтын хугацаа болон хайгуулын хугацаа нь харилцан бие даасан хугацаа бөгөөд ашиглалтын хугацаа нь үр ашигтай нээлт хийснээс өдрөөс хойш 20 жилийн хугацаанд хүчинтэй юм. Газрын тосны газрын даргын 2010 оны 18 дугаар тогтоолын 2 дугаар заалтын дагуу Тосон-Уул (19) талбайн олборлолтонд шилжсэн хугацааг 2010 оны 02 дугаар сарын 22-ны өдөр, Тамсаг (21) талбайн олборлолтонд шилжсэн хугацааг 2012 оны 12 дугаар сарын 6-ны өдөр гэж гүйцэтгэгч, МГТ хамтран тогтоосон. Тиймээс 19, 21-р талбайн БХГ нь хүчинтэй хугацаандаа байгаа болно. Хавсралт 1-ээс харна уу.

Хоёр. Бусад саналыг Хавсралт 2-оос харна уу.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ)



ЖАН ДӨЧУАН

“Петрочайна Дачин Тамсаг” ХХК-д хариу тайлбар

№	ПЧДТ ХХК-аас ирүүлсэн санал, тайлбар	ҮАГ-ын хариу тайлбар
1	<p>“Petrochina Daqing Tamsag Mongolia (XIX)” Ltd- “Петрочайна Дачин Тамсаг Монгол (XIX)” ХХК “Petrochina Daqing Tamsag Mongolia (XXI)” Ltd – “Петрочайна Дачин Тамсаг Монгол (XXI)” ХХК “Petrochina Daqing Tamsag” Ltd – “Петрочайна Дачин Тамсаг” ХХК</p> <p>19, 21-р талбайн компаниудын бүртгэлтэй газар нь Их Британийн Каймань арал ба “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн бүртгэлтэй газар нь Монгол Улсын Улаанбаатар хот юм. “Петрочайна Дачин Тамсаг” ХХК нь “Петрочайна Дачин Тамсаг Монгол (XIX)” ХХК, “Петрочайна Дачин Тамсаг Монгол (XXI)” ХХК-ийн толгой компани биш бөгөөд дээрх гурван компани нь өөр өөр хуулийн субъект, нягтлан бодох бүртгэлийн субъект юм. 19, 21-р талбайн компаниудын санхүүгийн мэдээллийг “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн санхүүгийн тайланд нэгтгэвэл “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн санхүүгийн тайлангийн мэдээллийг гажуудуулж санхүүгийн баланс болон тайлан зөрүүтэй гарах тул нэгдэх нөхцөл хангагдахгүй.</p> <p>Санал: Сангийн яамнаас гаргасан санхүүгийн тайлангийн загварт үндэслэн цаасан хэлбэрээр нэгтгэсэн тайлан гаргаж, дээрх гурван компанийн санхүүгийн мэдээллийг тусгаснаар “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн данс тайлантай тохирч, мэдээлэл үнэн зөв байх боломжтой ба нөгөө талаас Монгол Улсын Засгийн газрын байгууллагуудад тайлагнасан санхүүгийн мэдээлэлтэй адил байх баталгаа болох юм.</p>	<p>БХГ-ний 13 дугаар зүйлийн 13.1-д “Гэрээлэгч ...нягтлан бодох бүртгэлийн нийтлэг зарчмын дагуу хөтөлнө” гэж заасан. “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-аас ирүүлсэн тайлбарт: “Петрочайна Дачин Тамсаг” ХХК БХГ-ний гэрээлэгч мөн гээд 19, 21 гэсэн 3 өөр компани гэж тайлбар ирүүлсэн нь агуулгын хувьд зөрүүтэй байна.</p> <p>2005 онд анхны гэрээлэгчээс хувьцаа худалдан авах замаар Дачин Ойлфийлд ХХК-ийн эрх шилжүүлэх тухай тохиролцоо хийж бүх эрх үүргийг шилжүүлж авсан байна. БХГ-ний 24 зүйлийн 24.1-д “Анхдагч гэрээлэгч болон гүйцэтгэгч бус дараагийн гэрээлэгч нь Монгол Улсын Засгийн газрын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр өөрсдийн эрх үүргийг бүрнээр буюу аль нэг хэсгийг бусдад шилжүүлж болохгүй” гэсэн заалтыг зөрчсөн. Энэ талаар судалж тайлангийн 24 дүгээр хуудсанд нэмж орууллаа.</p> <p>Мөн “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн данс тайлантай тохирч, мэдээлэл үнэн зөв байх боломжтой гэж одоо буруу тайлагнаж байгаагаа хүлээн зөвшөөрсөн атлаа цаасан хэлбэрээр засах боломжтой гэх мэтээр хууль тогтоомж, стандарт, БХГ-нд нийцүүлэн залруулахгүй байх утга бүхий тайлбар ирүүлснийг хүлээн авах боломжгүй байна.</p> <p>Гэрээлэгчийн хувьд газрын тостой холбогдсон бүх үйл ажиллагаагаа БХГ-д заасны дагуу нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмын дагуу иж бүрэн, үнэн зөв тайлагнаагүй БХГ-ээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй байгаа тул МУЗГ-т гэрээгээ цуцлах зөвлөмж хүргүүлсэн болно.</p> <p>СЯ-нд зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх, УУХҮС-д холбогдох албан тушаалтанд сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага тус тус хүргүүлсэн.</p>
2	<p>БХГ-ний тодорхойлолт хэсэгт "Үр ашигтай нээлт" гэдэг нь гэрээлэгчийн тооцоолсон олборлох нөөц, газрын тосны үнэ, олборлолтын зардал зэргийг оролцуулсан техник-эдийн засгийн зохих хүчин зүйлсийг харгалзан үр ашигтайгаар олборлох боломжтой гэж гэрээлэгчийн тогтоосон нэг эсвэл хоёр (2) түүнээс дээш тооны байгалийн агууламжийг хэлнэ" гэж заасан байдаг. БХГ-ний ARTICLE II DEFINATIONS хэсгийн “COMMERCIAL DISCOVER” means a reservoir or a group of two (2) or more reservoirs containing Petroleum which the Contractor determines to be worthy of being developed commercially, taking into consideration</p>	<p>Аудитаар эдийн засгийн үр ашгаас гадна БХГ болон хууль зүйн талаас нь авч үзсэн. Үүнд: БХГ-ний 4 дүгээр зүйл нь "Үр ашигтай нээлт" хийвэл өртөг зардлыг нөхөж авна гэсэн урьдчилан болзол заасан нөхцөлт гэрээ байсан. Гэтэл гол болзол болох "Үр ашигтай нээлт" хийсэн талаарх баримт материал олдохгүй байгааг тайланд тодорхой тусгасан. Тодруулбал: Гэрээний хэрэгжилтийг үнэлсэн, баримт материал байхгүй, ирүүлээгүй байх тул уг төслийн эдийн засгийн үр ашиг талаас нь авч үзсэн.</p>

	<p>relevant technical and economic factors, including Contractor's estimates of recoverable reserves, prices of Petroleum and cost of development. Аудитын зүгээс уг тодорхойлолтыг зөвхөн эдийн засгийн үр ашиг талаас нь үнэлж дүгнэж байгаа нь өрөөсгөл бөгөөд гэрээний дээрх агуулгатай зөрчилдөж байгаа болно.</p> <p>Үр ашигтай нээлт ба төслийн эдийн засгийн ерөнхий үр ашиг нь ижил ойлголт биш юм. Үр ашигтай нээлт гэдэг нь хайгуулын үеийн ойлголт ба хайгуулын хугацаанд тосны цооногуудад дүн шинжилгээ хийж тодорхойлон улмаар тос олборлох боломжтой бөгөөд өртөг зардлаа нөхөх боломжтой гэж гэрээлэгчийн байгалийн агууламжийг хэлнэ. Төслийн нийт эдийн засгийн үр ашиг гэдэг нь төслийн бүх хугацааны орлого зарлагын тэнцлийг хэлнэ.</p> <p>Хугацааны дарааллын хувьд эхлээд өрөмдлөгийн үйл ажиллагаа явуулж, тосны цооногоос газрын тос гарсны дараа гүйцэтгэгч болон Засгийн газрын байгууллага үр ашигтай нээлт мөн эсэхийг үнэлж, баталгаажуулдаг. Хэрэв үр ашигтай нээлт болохыг баталгаажуулбал олборлолтын үе шатанд орж, газрын тосны үйл ажиллагаанд оруулсан бүх хөрөнгө оруулалтыг нөхөж авдаг, Хайгуулын хугацаанд ямар нэгэн үр ашигтай нээлт илрүүлээгүй тохиолдолд гүйцэтгэгч компанийн хөрөнгө оруулалт үр ашиггүй болж, орлого байхгүй тул нөхөж авах боломжгүй болно. Түүнчлэн БХГ-ний 25.4 заасанчлан уг гэрээ нь Англи болон Монгол хэл дээр үйлдэгдэх ба аливаа маргаан гарсан тохиолдолд Англи хэл дээрх хувилбар нь давуу эрхтэй гэж заасанчлан БХГ-ний 2 дугаар зүйлд Үр ашигтай нээлт гэж тодорхойлсон тодорхойлолтын Монгол хэл дээрх орчуулга нь агуулгын хувьд зөрүүтэй ойлголт төрүүлэхүйц байгааг дурдах нь зүйтэй</p>
<p>3 2004 оны 1-р сарын 31-нд SOCO болон ГТГ (Гарын үсэг зурсан хүн О.Даваасамбуу) хооронд хайгуулын хугацааг сунгах баримт бичигт гарын үсэг зурсан ба үүнд SOCO international компанийн эзэмшиж буй 19, 21, 22-р талбай болон Dongshen Petroleum Development Group-т хамаарах талбайн хугацааг сунгасан. Энэхүү баримт бичиг нь ГТГ болон SOCO компанийн хооронд байгуулагдсан ба худалдан авах үед шилжүүлэн өгөөгүй тул Газрын тосны газар эсвэл Үндэсний архиваас лавлах шаардлагатай. БХГ-нд заасан газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа нь хайгуулын хугацаа, ашиглалтын хугацаа гэсэн хоёр үе шаттай. Манай компани болон Монгол Газрын тос компанийн байгуулсан БХГ-ний 5.5-р зүйл Олборлолтын хугацаа хэсэгт "Хайгуулын хугацаа аяндаа дууссан буюу түүнийг бусад хэлбэрээр зогсоосон эсэхийг үл харгалзан энэ гэрээ үр ашигтай нээлт нэг бүрийн хувьд, тухайн үр ашигтай нээлтийг бүртгэсэн өдрөөс хойш 20 жилийн хугацаа (олборлолтын хугацаа)-нд</p>	<p>/Дэлгэрэнгүйг хуудас 6-10/ Нөгөө талаас гэрээлэгч "Үр ашигтай нээлт"-ийн талаар маш сайн тайлбарлаж, ойлгож байгаа хэдий ч БХГ-ний энэ заалтаа талууд мөрдөж ажиллаагүй байсан тул тайлбарыг хүлээж авах боломжгүй байна.</p> <p>БХГ-нд гагцхүү гэрээлэгч үр ашигтай нээлт гэж тооцон мэдэгдэж, бүртгэсэн өдрөөр хугацааг тооцохоор байхад МГТ болон гүйцэтгэгч нар тогтоох нь БХГ, холбогдох хуулиудыг зөрчиж байна. Тайлбарт дурдсанаар: Газрын тосны газрын даргын 2011 оны 06 дугаар 29-ний 111 дүгээр тушаалаар БХГ-т Тосон Уул XIX талбайд газрын тосны ашиглалт /Үйлдвэрлэлийн олборлолт/ явуулж эхэлсэн огноог 2010 оны 2 дугаар сарын 22-ны өдрөөр, 2012 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 207 дугаар тушаалаар БХГ-т Тамсаг XXI талбайд газрын тосны ашиглалт /Үйлдвэрлэлийн олборлолт/ явуулж эхэлсэн огноог 2012 оны 12 дугаар сарын 06-ны өдрөөр тооцож, ГТГ-ын даргын тушаал гаргасан нь БХГ-ний 24 зүйлийн 24.1-д "Анхдагч гэрээлэгч болон гүйцэтгэгч бус дараагийн гэрээлэгч нь Монгол Улсын Засгийн газрын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр өөрсдийн эрх</p>

хүчин төгөлдөр хэвээр байна" гэж заасан. Иймд ашиглалтын хугацаа болон хайгуулын хугацаа нь харилцан бие даасан хугацаа бөгөөд ашиглалтын хугацаа нь үр ашигтай нээлт хийснээс өдрөөс хойш 20 жилийн хугацаанд хүчинтэй юм. Газрын тосны газрын даргын 2010 оны 18 дугаар тогтоолын 2 дугаар заалтын дагуу Тосон Уул (19) талбайн олборлолтод шилжсэн хугацааг 2010 оны 02 дугаар сарын 22-ны өдөр, Тамсаг (21) талбайн олборлолтод шилжсэн хугацааг 2012 оны 12 дугаар сарын 6-ны өдөр гэж гүйцэтгэгч, МГТ хамтран тогтоосон Тиймээс 19, 21-р талбайн БХГ нь хүчинтэй хугацаандаа байгаа болно. Хавсралт 1-ээс харна уу.

үүргийг бүрнээр буюу аль нэг хэсгийг бусдад шилжүүлж болохгүй" гэсэн заалтыг зөрчиж, эрх мэдлээ хэтрүүлсэн гэж үзэж хуулийн байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэв.

Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд

1. “Петрочайна Дачин Тамсаг” ХХК нь газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд хамаарах ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд иж бүрэн, үнэн зөв тайлагнаагүй тул аудитаар үр дүнг баталгаажуулах боломжгүй байна.
2. БХГ-г зөрчиж 7,228.7 тэрбум төгрөгийн өртөг зардлыг нөхөж авахаар хуримтлуулж тооцсон нь МУ-д ногдох газрын тосны орлогын хэмжээг бууруулах эрсдэлтэй байна.
3. Тосон Уул XIX талбайн БХГ-ний хэрэгжилтийг дүгнээгүй, хугацаа дууссан, эрх зүйн зохицуулалтгүй олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаагаас шалтгаалж Монгол Улсын эрх ашиг хөндөгдөж байна.
4. АМГТГ нь гэрээлэгчээс ирүүлсэн газрын тосны үйл ажиллагаатай холбоотой тайлан мэдээг санхүүгийн тайлантай уялдуулж хянаж шалгаагүйгээс нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлого хуваарилалтын тооцоо буруу илэрхийлэгдсэн байна.
5. АМГТГ нь Газрын тосны тухай хууль болон БХГ-нд заасан хяналт хэрэгжүүлэх чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүйгээс гэрээлэгч талд эрх зүйн зохицуулалтаар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх давуу байдал олгосон байна.
6. УУХҮЯ нь газрын тосны салбарын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлснээс аудитаар өгсөн зөвлөмж хэрэгжихгүй, алдаа зөрчил давтагдаж байна.

Зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Монгол Улсын Их Хуралд толилуулах нь:

1. Газрын тосны олборлолтын үйл ажиллагаанаас Монгол Улсад ногдох хувь хэмжээг нэмэгдүүлэх, олборлосон бүтээгдэхүүнийг захиран зарцуулах, хяналт тавих эрх зүйн зохицуулалтыг бий болгохыг толилуулж байна. *БХГ зөвхөн олборлосон тос хуваах зохицуулалттай. Гэвч өнөөгийн байдалд гэрээт түүхий тосыг тээвэрлэх, худалдан борлуулах асуудлыг АМГТГ гэрээлэгчтэй харилцан тохиролцож протокол үйлдэж шийдвэрлэж байна/*

Монгол Улсын Засгийн газарт:

1. БХГ-ний дагуу үр ашигтай нээлтийн цооногийг илрүүлсэн хугацаатай уялдуулан бүртгэлийг үнэн зөв хийлгэх, үүнд хяналт хэрэгжүүлэх;
2. БХГ-ний "С" Хавсралт "Тооцооны журам"-ын 1.1-д "...гэрээлэгч буюу МУЗГ-ын хувьд шударга, эрх тэгш бус болох нь нотлогдвол талууд буцааж дээрх арга замын шударга, эрх тэгш бус аливаа зүйлийг залруулахад шаардлагатай өөрчлөлтүүдийн талаар тохиролцохыг хичээнгүйлэн эрмэлзэнэ" гэж заасныг хэрэгжүүлж ажиллах, үр дүнг тооцох, дотоод хяналтыг сайжруулах;
3. Гэрээлэгч БХГ-нд заагдсан эрх үүргээ бүрэн хэрэгжүүлэхгүй, зөрчил дутагдлыг давтан гаргаж байгааг таслан зогсоох арга хэмжээ авч, хариуцлага тооцох;
4. Газрын тосны олборлолт, борлуулалт, хөрөнгө оруулалтын, өртөг зардлын нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх;

Ашигт малтмал, газрын тосны газарт:

1. Гэрээлэгчтэй БХГ-ний холбогдох заалтуудыг хууль тогтоомжийн хүрээнд бүрэн мөрдөх талаар арга хэмжээ зохион байгуулж ажиллах;
2. Гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтыг хянахдаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу харилцагч санхүүгийн байгууллагын баталгаажуулсан цахим санхүүгийн тайлан, тодруулгыг үндэслэж шалгаж байх;
3. Харилцагч санхүүгийн байгууллагын баталгаажуулсан цахим санхүүгийн тайланд үндэслэн холбогдох байгууллага татвар, шимтгэл, хураамжийн тооцоо хийхээс гадна төрийн эрх бүхий байгууллага нь энэхүү цахим санд баталгаажсан аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан, тодруулгыг ашиглах;
4. Гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, газрын тосны экспорт, борлуулалтын орлого зөрүүтэй байвал хянан шалгаж, дүгнэлт тайланд бүрэн тусгаж ирүүлж байх;

Хавсралт 1

Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайн 1996-2022 оны газрын тосны олборлолт, экспортын мэдээ

/баррель, тонн/

ОН	ГАЗРЫН ТОСНЫ ОЛБОРЛОЛТ						ГАЗРЫН ТОСНЫ ЭКСПОРТ					
	Тосон-Уул XIX		Тамсаг XXI		Нийт олборлолт		Тосон-Уул XIX		Тамсаг XXI		Нийт экспорт	
	баррель	Тонн	баррель	тонн	баррель	тонн	баррель	тонн	баррель	тонн	баррель	тонн
1996												
1997												
1998	18,942	2,532			18,942	2,532	15,607	2,086			15,607	2,086
1999	19,556	2,614			19,556	2,614	18,094	2,419			18,094	2,419
2000	22,991	3,074			22,991	3,074	21,888	2,926			21,888	2,926
2001	60,101	8,035			60,101	8,035	58,615	7,836			58,615	7,836
2002	139,309	18,624			139,309	18,624	128,798	17,219			128,798	17,219
2003	150,606	20,135			150,606	20,135	143,788	19,224			143,788	19,224
2004	132,333	17,692			132,333	17,692	128,086	17,124			128,086	17,124
2005	91,810	12,274			91,810	12,274	89,898	12,018			89,898	12,018
2006	187,974	25,130			187,974	25,130	185,074	24,742			185,074	24,742
2007	575,491	76,937			575,491	76,937	564,826	75,512			564,826	75,512
2008	1,002,875	134,074			1,002,875	134,074	979,555	130,957			979,555	130,957
2009	1,358,020	181,554	7,091	950	1,365,111	182,503	1,324,646	177,092	7,000		1,331,646	177,092
2010	1,606,975	214,836			1,606,975	214,836	1,555,624	207,972			1,555,624	207,972
2011	1,975,324	263,870	92,343	12,335	2,067,666	276,205	1,936,475	258,679	83,457	11,148	2,019,931	269,828
2012	3,347,113	447,117	26,453	3,534	3,373,566	450,651	2,991,877	397,110	27,870	3,723	3,019,747	400,833
2013	4,131,325	550,256	796,558	106,095	4,927,883	656,351	3,890,502	515,438	761,016	105,444	4,651,518	620,882
2014	4,638,348	618,034	2,328,250	322,338	6,966,598	940,372	4,264,751	565,014	2,185,495	303,098	6,450,246	868,112
2015	4,926,600	654,814	3,361,662	465,072	8,288,262	1,119,886	4,448,932	589,760	3,228,207	445,656	7,677,139	1,035,416
2016	4,041,122	536,338	3,842,555	530,093	7,883,677	1,066,431	3,774,311	500,721	3,884,688	536,320	7,658,999	1,037,041
2017	3,388,478	448,833	3,903,966	539,568	7,292,444	988,401	3,353,003	445,564	3,823,457	529,011	7,176,460	974,575
2018	2,942,161	389,597	3,107,314	429,193	6,049,475	818,790	2,922,518	388,366	2,942,686	407,088	5,865,204	795,454
2019	3,172,441	420,312	3,323,393	458,879	6,495,834	879,191	3,097,985	410,693	3,076,598	424,964	6,174,583	835,657
2020	1,610,357	213,626	2,134,453	294,638	3,744,810	508,264	1,602,583	212,535	2,109,129	291,224	3,711,712	503,759
2021	2,064,453	273,596	2,280,188	314,798	4,344,641	588,394	1,924,796	255,215	2,178,461	300,816	4,103,257	556,031
2022	1,198,317	158,994	1,306,476	180,366	2,504,793	339,360	1,213,349	160,948	1,296,797	178,925	2,510,146	339,873
НИЙТ	42,803,022	5,692,897	26,510,701	3,657,860	69,313,723	9,350,757	40,635,581	5,397,170	25,604,860	3,537,417	66,240,441	8,934,588

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

Хавсралт 2



ГАЗРЫН ТОСНЫ ЭКСПОРТЫН МЭДЭЭ, МОНГОЛ УЛСАД ТӨВЛӨРҮҮЛСЭН ОРЛОГЫН СУДАЛГАА

ОН	Дундаж үнэ доллар	Тосон-Уул XIX		Тамсаг XXI		Петрочайна Дачин Тамсаг ХХК /XIX+XXI/		Доншен газрын тос (Монгол) ХХК		БҮГД		Үүнээс МУ-д төвлөрүүлсэн орлого	
		тонн	ам.доллар	тонн	ам.доллар	тонн	ам.доллар	тонн	ам.доллар	тонн	ам.доллар	ам.доллар	төгрөг
1996													
1997													
1998		2,086				2,086	-	3,900		5,986	-	64,089	
1999		2,419				2,419	-	7,948		10,367	-	147,412	
2000		2,926				2,926	-	6,168		9,094	-	336,491	
2001		7,836				7,836	-	3,849		11,685	-	225,701	
2002		17,219				17,219	-	-		17,219	-	469,424	
2003		19,224				19,224	-	2,118		21,342	-	754,211	
2004		17,124				17,124	-	7,475		24,599	-	1,333,095	
2005		12,018				12,018	-	13,707		25,725	-	2,319,049	
2006		24,742				24,742	-	21,417		46,159	-	4,982,407	
2007		75,512				75,512	-	34,555		110,067	-	14,052,350	
2008		130,957				130,957	-	11,130		142,087	-	21,933,648	
2009		177,092				177,092	-	86,104		263,196	-	26,777,776	34,936,193,515.9
2010		207,972				207,972	-	80,417		288,389	-	37,037,027	54,735,711,280.00
2011		258,679		11,148		269,828	-	75,517		345,345	-	64,730,619	82,016,930,586.91
2012		397,110		3,723		400,833	-	75,347		476,180	-	90,392,866	122,768,505,039.27
2013		515,438		105,444		620,882	-	71,097		691,979	-	121,241,806	184,761,600,761.14
2014		565,014		303,098		868,112	-	61,591		929,703	-	162,220,244	275,824,264,218.39
2015		589,760		445,656		1,035,416	-	64,345		1,099,761	-	81,448,567	160,628,589,147.97
2016		500,721		536,320		1,037,041	-	50,130		1,087,171	-	61,554,258	134,214,380,540.12
2017		445,564		529,011		974,575	-	47,042		1,021,617	-	81,245,863	198,039,704,892.68
2018		388,366		407,088		795,454	-	45,205		840,659	-	89,936,569	222,514,736,785.01
2019	55.43	410,693	174,068,483.73	424,964	173,218,456.34	835,657	347,286,940	52,022		887,679	347,286,940	87,274,594	232,267,132,458.52
2020	38.06	212,535	61,899,388.77	291,224	76,571,959	503,759	138,471,348	50,266		554,025	138,471,348	36,415,558	102,757,324,312.16
2021	63.56	255,215	119,017,237	300,816	135,517,262	556,031	254,534,498	34,353		590,384	254,534,498	69,568,720	198,145,306,083.00
2022		160,948		178,925		339,873	-	13,394		353,267	-	48,300,273	160,996,054,219.67
2023.04.30												15,187,813	48,385,102,470.0
НИЙТ		5,397,170	354,985,109	3,537,417	385,307,677	8,934,588	740,292,786	919,096	-	9,853,684	740 292 786		2,253,342,523,410.7

Хавсралт 3

Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайн 1993-2018 онд баталгаажуулсан өртөг нөхөгдөх зардлын тооцоо

/ам.доллар/

Он	Баталгаажуулсан өртөг нөхөгдөх зардлын дүн			Өртөгт тосоор нөхөгдсөн дүн			Нөхөгдөх зардал		
	XIX талбай	XXI талбай	Дүн	XIX талбай	XXI талбай	Дүн	XIX талбай	XXI талбай	Дүн
1993	66,000.00		66,000.00			-	66,000.00	0	66,000.00
1994	445,590.00		445,590.00			-	445,590.00	0	445,590.00
1995	8,551,299.00	13,200.00	8,564,499.00			-	8,551,299.00	13,200.00	8,564,499.00
1996	1,945,546.00	4,288,263.00	6,233,809.00	880		880.00	1,944,666.00	4,288,263.00	6,232,929.00
1997	11,428,474.00	3,627,196.00	15,055,670.00			-	11,428,474.00	3,627,196.00	15,055,670.00
1998	14,641,500.00	1,556,968.00	16,198,468.00	58,871.00		58,871.00	14,582,629.00	1,556,968.00	16,139,597.00
1999	1,744,080.00	-107,506.00	1,636,574.00	77,830.00		77,830.00	1,666,250.00	-107,506.00	1,558,744.00
2000	2,688,384.00	188,023.00	2,876,407.00	149,191.00		149,191.00	2,539,193.00	188,023.00	2,727,216.00
2001	5,594,029.00	135,002.00	5,729,031.00	201,128.00		201,128.00	5,392,901.00	135,002.00	5,527,903.00
2002	5,076,877.00	2,161,285.00	7,238,162.00	782,136.00		782,136.00	4,294,741.00	2,161,285.00	6,456,026.00
2003	8,266,076.00	2,212,278.00	10,478,354.00	1,145,239.00		1,145,239.00	7,120,837.00	2,212,278.00	9,333,115.00
2004	7,578,207.00	472,867.00	8,051,074.00	1,354,404.00		1,354,404.00	6,223,803.00	472,867.00	6,696,670.00
2005	12,688,551.00	1,863,948.00	14,552,499.00	1,464,933.00		1,464,933.00	11,223,618.00	1,863,948.00	13,087,566.00
2005	-200,000.00	-200,000.00	-400,000.00			-	-200,000.00	-200,000.00	-400,000.00
2006	88,821,150.00	12,330,813.00	101,151,963.00	3,746,303.00		3,746,303.00	85,074,847.00	12,330,813.00	97,405,660.00
2007	159,313,618.39	94,199,525.71	253,513,144.10	15,472,116.59		15,472,116.59	143,841,501.80	94,199,525.71	238,041,027.51
2008	183,240,877.40	46,653,638.22	229,894,515.62	33,069,015.13		33,069,015.13	150,171,862.27	46,653,638.22	196,825,500.49
2009	253,022,725.21	100,400,479.98	353,423,205.19	28,848,931.72	166,422.44	29,015,354.16	224,173,793.49	100,234,057.54	324,407,851.03
2010	80,934,622.15	14,367,851.65	95,302,473.80	42,914,604.11		42,914,604.11	38,020,018.04	14,367,851.65	52,387,869.69
2010	6,172,056.50		6,172,056.50			-	6,172,056.50	0	6,172,056.50
2011	213,198,485.74	37,910,097.53	251,108,583.27	77,741,454.26	3,414,767.25	81,156,221.51	135,457,031.48	34,495,330.28	169,952,361.76
2012	261,038,037.85	9,043,693.85	270,081,731.70	122,653,011.76	1,148,797.64	123,801,809.40	138,385,026.09	7,894,896.21	146,279,922.30
2013	154,941,320.50	171,167,310.47	326,108,630.97	144,171,718.66	28,919,393.84	173,091,112.50	10,769,601.84	142,247,916.63	153,017,518.47
2014	185,371,500.00	203,003,500.00	388,375,000.00	143,891,000.00	75,517,700.00	219,408,700.00	41,480,600.00	127,485,700.00	168,966,300.00
2015	146,291,000.00	178,231,700.00	324,522,700.00	65,875,800.00	49,296,300.00	115,172,100.00	80,415,300.00	128,935,400.00	209,350,600.00
2016	81,839,600.00	83,675,600.00	165,515,200.00	42,343,200.00	47,774,900.00	90,118,100.00	39,496,400.00	35,900,700.00	75,397,000.00
2017	92,034,100.00	96,206,900.00	188,241,000.00	54,083,000.00	65,118,000.00	119,201,000.00	37,951,100.00	31,088,900.00	69,040,100.00
2018	115,568,300.00	116,738,500.00	232,306,800.00	63,834,800.00	66,759,500.00	130,594,300.00	51,733,500.00	49,979,100.00	101,712,600.00
Нийт	2,102,302,006.74	1,180,141,134.41	3,282,443,141.15	843,879,567.23	,115,781.17	1,181,995,348.40	1,258,422,639.51	842,025,353.24	2,100,447,892.75

Хавсралт 4

/ам.доллар/

2019 оны Хяналт, шалгалтаар гэрээлэгчдийн өртөг нөхөгдөх зардлын хэмжээ				
Хөрөнгө оруулалт-ӨНЗ	мөр дугаар	Тосон Уул XIX	Тамсаг XXI	Нийт дүн
ӨНЗ тайлангаар	A	106,306,358.6	89,779,807.6	196,086,166.3
Хасагдсан	B	(50,404,814.3)	(40,277,518.3)	(90,157,139.4)
Ашиглаагүй бараа материал	C	(9,035,278.6)	(4,915,955.1)	(13,951,233.7)
ӨНЗ-ын дүн	D=A+B+C	46,866,265.7	44,586,334.2	91,977,793.1
Захиргааны зардал 10 %	E=D*10%	4,686,626.6	4,458,633.4	9,197,779.3
Нийт дүн	F=D+E	51,552,892.3	49,044,967.6	101,175,572.4
Тухайн жилд өртөгт тосоор нөхөгдсөн	G	(20,289,637.3)	(26,419,506.8)	(46,709,144.1)
ӨНЗ-ын нийт дүн	H=F-G	31,263,255.0	22,625,460.8	53,888,715.8
2020 оны Хяналт, шалгалтаар гэрээлэгчдийн өртөг нөхөгдөх зардлын хэмжээ				
ӨНЗ тайлангаар	A	57,430,364.8	53,071,319.6	110,501,684.5
Хасагдсан	B	(30,972,583.9)	(29,515,534.7)	(60,488,118.6)
Ашиглаагүй бараа материал	C	(10,831,418.6)	(9,448,084.7)	(20,279,503.2)
ӨНЗ-ын дүн	D=A+B+C	15,626,362.4	14,107,700.3	29,734,062.7
2019 оны өглөгөөс төлөгдсөн дүн	E	4,381,548.3	1,928,182.8	6,309,731.1
дүн	F=D+E	20,007,910.7	16,035,883.1	36,043,793.7
Захиргааны зардал 10 %	G=F*10%	2,000,791.1	1,603,588.3	3,604,379.4
Нийт дүн	H=F+G	22,008,701.7	17,639,471.4	39,648,173.1
Тухайн жилд өртөгт тосоор нөхөгдсөн	I	(20,289,637.3)	(26,419,506.8)	(46,709,144.1)
ӨНЗ-ын нийт дүн	J=I+H	1,719,064.4	(8,780,035.4)	(7,060,971.0)
2021 оны Хяналт, шалгалтаар гэрээлэгчдийн өртөг нөхөгдөх зардлын хэмжээ				
ӨНЗ тайлангаар	A	56,760,363.2	55,514,509.4	112,274,872.6
Хасагдсан	B	(15,444,220.1)	(22,829,219.3)	(38,273,439.4)
Ашиглаагүй бараа материал	C	(9,301,516.5)	(9,195,697.6)	(18,497,214.0)
ӨНЗ-ын дүн	D=A+B+C	32,014,626.6	23,489,592.6	55,504,219.2
2019, 2020 оны өглөгөөс ӨНЗ-д тооцох дүн	E	43,590,682.0	53,499,355.0	97,090,036.9
2019, 2020 оны өглөгөөс төлөгдсөн ӨНЗ-аас хасагдсан дүн	F	(14,832.9)	(9,254,594.7)	(9,269,427.6)
дүн	G=D+E+F	75,590,475.8	67,734,352.8	143,324,828.6
Захиргааны зардал 10 %	H*10%	7,559,047.6	6,773,435.3	14,332,482.9
Нийт дүн	I=H+G	83,149,523.3	74,507,788.1	157,657,311.4
Тухайн жилд өртөгт тосоор нөхөгдсөн	J	(42,783,762.3)	(50,330,276.1)	(93,114,038.4)
ӨНЗ-ын нийт дүн	K=I+J	40,365,761.0	24,177,512.0	64,543,273.0

ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

/Мянган ам.доллар, мянган төгрөг/

д/д	Зөрчлийн товч утга	Мөнгөн дүн ам.доллар	Хариуцлага тооцох албан шаардлага өгсөн	Зөрчил арилгах албан шаардлага	Хууль хяналтын байгууллагад шилжүүлэх
БҮЛЭГ-1.					
1	БХГ-ний 4 дүгээр зүйлд зөвхөн үр ашигтай нээлт хийсэн нөхцөлд гэрээлэгч өртөг зардлыг нөхөж авахаар заасан боловч Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайд үр ашигтай нээлт илрүүлсэн баримт мэдээлэл байхгүй, Засгийн газрын төлөөлөгчид мэдэгдсэн эсэх нь тодорхойгүй байхад 1996-2018 оны хугацаанд 1,181.9 сая ам.долларын өртөг зардлыг нөхөн авч, 2,100.4 сая ам.долларын өртөг зардлыг нөхөж авахаар хуримтлуулан тооцсон байна.	2,100,447.9		Зөрчил арилгах албан шаардлага өгсөн	Хууль хяналтын холбогдох байгууллагад шилжүүлсэн
2	Гэрээний талууд хайгуулын хугацааг хэрхэн сунгасан, олборлолтод хэзээ шилжсэн талаарх үндэслэлтэй тайлбар, тодруулга, нотлох баримтыг гаргаж чадахгүй байна. Тосон Уул XIX талбайд Өртөг нөхөгдөх зардлыг анх нөхөж авсан 1996 оноос тооцвол 2016 онд анхны үр ашигтай цооногийн хугацаа дуусаж, үр ашигтай нээлт бүртгэгдэх сүүлийн хугацаагаар тооцвол 2023 оны 4 дүгээр сард Тосон Уул XIX талбайн БХГ-ний хугацаа бүрэн дууссан байна. Гэрээний талууд БХГ-ээр тогтоосон хайгуулын хугацааг хэрхэн сунгасан, үр ашигтай нээлтийг хэзээ бүртгүүлсэн талаарх мэдээ, тайлан, тайлбар, тодруулга нь тодорхойгүй, нотлох баримтаар хангагдахгүй байна.			Зөрчил арилгах албан шаардлага өгсөн	Хууль хяналтын холбогдох байгууллагад шилжүүлсэн
3	Австралийн Комманд Петролеум компаниар толгойлуулсан олон улсын газрын тосны консорциум нь "СОКО Монгол Инк"-д эрхээ шилжүүлсэн тухай болон Соко Тамсаг Монгол ХХК-иас Дачин Ойлфилд Лимитед компанид эрх шилжүүлсэн тохиролцоо нь БХГ-ний 24 дүгээр зүйлд эрх шилжүүлэлтийг МУЗГ-ын бичгээр өгсөн зөвшөөрлийн дагуу олгохоор заасныг хэрэгжүүлж ажиллаагүй нь байгалийн хэвлийд хууль бусаар халдсан байж болзошгүй байна.			Зөрчил арилгах албан шаардлага өгсөн	Хууль хяналтын холбогдох байгууллагад шилжүүлсэн
4	Ашигт малтмал, газрын тосны газар /хуучнаар Газрын тосны хэрэг эрхлэх газар/ хуулиар олгогдоогүй эрх эдэлж гэрээлэгчтэй 2004 онд нэмэлт хэлэлцээр хайгуулын хугацааг 5 хүртэл жилээр сунгахаар тохиролцсон нь БХГ-тэй нийцэхгүй байна.			Зөрчил арилгах албан шаардлага өгсөн	Хууль хяналтын холбогдох байгууллагад шилжүүлсэн
5	Гэрээлэгч, Ашигт малтмал, газрын тосны газар /хуучнаар Газрын тосны хэрэг эрхлэх газар/ хооронд 2004 онд байгуулсан түүхий тос тээвэрлэх, борлуулах тухай протоколоор борлуулалтын зардлыг Монголын талаас эргүүлэн авахаар тохирсон нь БХГ-тэй нийцээгүй, уг хэлэлцээр нь хүчин төгөлдөр эрх зүйн баримт бичиг болох нь тодорхой бус.	82,730.2		Зөрчил арилгах албан шаардлага өгсөн	Хууль хяналтын холбогдох байгууллагад шилжүүлсэн
6	Ашигт малтмал, газрын тосны газар нь гэрээлэгчээс ирүүлсэн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтыг анхан шатны баримтад үндэслэн санхүүгийн тайланд тусгасан эсэхийг хянаж хүлээж аваагүй, үнэн зөв дүгнэлт тайланг Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй.		Хариуцлага тооцох албан шаардлага өгсөн		
7	Газрын тосны чиглэлээр 2005 оноос хойш үйл ажиллагаа эрхэлж байгаа "Петрочайна Дачин Тамсаг" ХХК нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг мөрдөхгүй, үндсэн үйл ажиллагаатай холбоотой ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд иж бүрэн тусгаагүй байхад Сангийн яам нь холбогдох хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй.			Зөрчил арилгах албан шаардлага өгсөн	
дүн /мянган ам.доллар/		2,183,178.0			

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

АМГТГ-аас ирүүлсэн дүгнэлт, тайланг баримт материалтай тулган шалгахад илэрсэн зөрчил				
1	Гэрээгээр гүйцэтгэх ажил үйлчилгээний зардалд мөнгөөр төлөгдөөгүй төлбөр тооцоог Тосон-Уул XIX талбайд 15,416,271.9 ам.доллар, Тамсаг XXI талбайд 25,915,613.2 ам.доллар, нийт 41,331,885.1 ам доллароор илүү тооцож тусгасан	41,331.9		
2	Тайлант оны хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны зардлын төсөвт тусгагдаагүй, төсвийн гүйцэтгэлд АМГТГ-аар хяналт хийгдээгүй Тосон-Уул XIX талбайд 4,180,855.2 ам.доллар, Тамсаг XXI талбайд 4,456,400.0 ам.доллар, нийт 8,637,255.2 ам.долларыг зарцуулсан байна.	8,637.3		
3	Нийгмийн даатгал, татвар төлөөгүй хятад ажиллагсдын цалин, бусад захиргааны зардал Тосон-Уул XIX талбайд 18,136,366.2 ам.доллар, Тамсаг XXI талбайд 13,571,059.1 ам.доллар, нийт 31,707,425.3 ам.долларыг ӨНЗ-аар тайлагнасан	31,707.4		
4	Тухайн ажил гүйлгээ гарсныг нотлох анхан шатны баримтын бүрдэл дутуу, баримтгүй Тосон-Уул XIX талбайд 377,391.0 ам.доллар, Тамсаг XXI талбайд 2,500,437.3 ам.доллар, нийт 2,877,828.3 ам.долларын ажил гүйлгээг бүртгэж тайлагнасан	2,877.8		
5	Тосон-Уул XIX талбайд 846,056.8 ам.доллар, Тамсаг XXI талбайд 1,055,907.6 ам.доллар, нийт 1,901,964.4 ам.долларын төлсөн татвар хураамж торгууль, төлөөлөгчийн болон сургалт, урамшууллын төлбөр, төрийн болон төрийн бус байгууллагуудад олгосон хандивыг ӨНЗ-д тооцож тайлагнасан	1,902.0		
6	Бараа материалын 2019-2021 оны жилийн эцсийн зарцуулаагүй үлдэгдэл Тосон-Уул XIX талбайд 9,665,796.6 ам.доллар, Тамсаг XXI талбайд 9,405,004.9 ам.доллар, нийт 19,070,801.5 ам.долларын материалыг зарцуулснаар ӨНЗ-д тооцож тайлагнасан	19,070.8		
7	Гэрээлэгч нь Борлуулалтын тайланд борлуулсан тосонд технологийн хорогдол тооцож хасан Тосон -Уул XIX талбайд нийт 39,438.2 баррель тос, борлуулсан тосны орлогыг 2,090,689.2 ам.доллороор дутуу тооцсон.	2,090.7		
8	Гэрээлэгч нь Борлуулалтын тайланд борлуулсан тосонд технологийн хорогдол тооцож хасан Тамсаг XXI талбайд 49,837.5 баррель тос, борлуулсан тосны орлогыг 2,648,217.0 ам.доллороор дутуу тооцсон.	2,648.2		
9	Тосон-Уул XIX талбайд ГТНАТ тооцож, төсөвт төвлөрүүлээгүй тул өмнөх аудитын тогтоосон 5.0 хувиар тооцоход 15,574,184.1 ам.доллар төсөвт төвлөрүүлээгүй. Гэрээлэгч 2019-2021 онд ГТНАТ-ийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн төлөөгүй байна.	15,570.2		
10	Тамсаг XXI талбайд тооцсон ГТНАТ нь тооцооллын зөрүүгээс шалтгаалан 2019-2021 онд 348,004.66 ам.доллар дутуу тооцсон.	299.5		
11	Гэрээлэгч, АМГТГ нь экспортын тээврийн зардлыг хүргэлтийн цэг дэх буулгалтын огноогоорх ASMT1250-820 хүснэгтээр тооцсон баррель тосны хэмжээг тээврийн гэрээний нэгж үнээр тооцон баталгаажуулсан байна. Экспортын тээврийн хөлсний тооцоог компани тус бүрээр дэлгэрэнгүй бүртгэл хөтлөөгүй, төлбөрийн нэхэмжлэлд нэгжийн үнийг гэрээнээс зөрүүтэй дүнгээр тооцсон, өглөгийн журналд зөвхөн эхний, эцсийн үлдэгдлийг бүртгэсэн байна. Аудитын тулгалтаар 2 талын тооцоо нийлж борлуулалтын тайланд баталгаажуулсан дүнг тээврийн компаниудтай тооцоо нийлээгүй, гэрээ дүгнэсэн акт хавсаргаагүй, нотлох баримт дутуу Тосон-Уул XIX талбайд 686,307.5 ам.доллар, Тамсаг	2,027.1		

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын тайлан

	XXI талбайд 2,072,479.9 ам.доллар, нийт 2,758,787.3 ам долларын зардал илүү тайлагнасан.				
12	Гэрээлэгч 2020 оны Матад, Халх гол сумын татварын усны төлбөр барагдуулах актыг үндэслэн, нэхэмжлэхийн дагуу ХХБ-ны дансанд төлбөр хийсэн боловч Протоколын 8-р хавсралтын Тосон-Уул XIX талбайд 89.517 м3 усны зөрүүтэй баталгаажуулсан. Аудитын тулгалтаар протоколоос Тосон-Уул XIX талбайн усны олборлолт 4.49 м3 усны зөрүү үүссэнийг тохируулан, Тосон-Уул XIX талбайд 795,787.0 м3 усны олборлолтыг тайлагнаагүй, 339,243.40 ам.доллар ус ашигласан төлбөр төлөөгүй байна.	339.2			
13	Гэрээлэгч 2020 оны Матад, Халх гол сумын татварын усны төлбөр барагдуулах актыг үндэслэн, нэхэмжлэхийн дагуу ХХБ-ны дансанд төлбөр хийсэн боловч Протоколын 8-р хавсралтын Тамсаг XXI талбайд 1,722,632.0 м3 усны зөрүүтэй баталгаажуулсан. Аудитын тулгалтаар протоколоос Тамсаг XXI талбайд 1,722,632.0 м3 усны олборлолтыг тайлагнаагүй, 728,392.40 ам.долларын ус ашигласан төлбөр төлөөгүй байна.	728.4			
14	Гэрээлэгч 2020 онд Тосон-Уул XIX талбайн 339,243.40 ам.доллар, Тамсаг XXI талбайн 728,392.40 ам.долларын ус ашигласан төлбөр төлөөгүй байна.	1,067.0			
дүн /мянган ам.доллар/		130,297.49			
нийт дүн /мянган ам.доллар/		2,313,475.54			
Нийт дүн /мянган төгрөг/		7,949,541,515.79			
Жич: Ханш 2023 он 11 дүгээр сарын 27-ны өдөр 1\$=3436.19₮,					



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 12 дугаар сарын 15 № 1136/АО110001

Улаанбаатар хот

СНАГ-2023/11-НА-НА

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Газрын тосны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2, 37 дугаар зүйлийн 37.2, 37.3 дахь хэсгийг тус тус үндэслэн газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтыг баталгаажуулах аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Ашигт малтмал, газрын тосны газар нь гэрээлэгчээс ирүүлсэн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтыг анхан шатны баримтад үндэслэн санхүүгийн тайланд тусгасан эсэхийг хянаж хүлээж аваагүй, үнэн зөв дүгнэлт тайланг Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй.
2. УАГ-аас буюу өмнөх аудитаар илрүүлсэн зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх 3 албан шаардлага, 5 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, ...албан үүргээ биелүүлээгүй ...нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно”, Газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д “Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага анхан шатны баримтад үндэслэн гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтын болон санхүүгийн тайланг хянан шалгаж, дүгнэлт гаргасан тайлангаа төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ” гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Ашигт малтмал, газрын тосны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Баярмандалд Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд /Ж.Ганбаатар/-д даалгав.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР


Д.ЗАНДАНБАТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 12 дугаар сарын 15 № 1134/АД/70050
СНАГ-2023/11-НА-НА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Газрын тосны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2, 37 дугаар зүйлийн 37.2, 37.3 дахь хэсгийг үндэслэн газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтыг баталгаажуулах аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Бүтээгдэхүүн хуваах гэрээний 4 дүгээр зүйлд зөвхөн үр ашигтай нээлт хийсэн нөхцөлд гэрээлэгч өртөг зардлыг нөхөж авахаар заасан боловч Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайд үр ашигтай нээлт илрүүлсэн баримт мэдээлэл байхгүй, Засгийн газрын төлөөлөгчид мэдэгдсэн эсэх нь тодорхойгүй байхад 1996-2018 оны хугацаанд 1,181.9 сая ам.долларын өртөг зардлыг нөхөн авч, 2,100.4 сая ам.долларын өртөг зардлыг нөхөж авахаар хуримтлуулан тооцсон байна.
2. Гэрээний талууд хайгуулын хугацааг хэрхэн сунгасан, олборлолтод хэзээ шилжсэн талаарх үндэслэлтэй тайлбар, тодруулга, нотлох баримтыг гаргаж чадахгүй байна. Тосон Уул XIX талбайд Өртөг нөхөгдөх зардлыг анх нөхөж авсан 1996 оноос тооцвол 2016 онд анхны үр ашигтай цооногийн хугацаа дуусаж, үр ашигтай нээлт бүртгэгдэх сүүлийн хугацаагаар тооцвол 2023 оны 4 дүгээр сард Тосон Уул XIX талбайн Бүтээгдэхүүн хуваах гэрээний хугацаа бүрэн дууссан байна.
3. Гэрээний талууд БХГ-ээр тогтоосон хайгуулын хугацааг хэрхэн сунгасан, үр ашигтай нээлтийг хэзээ бүртгүүлсэн талаарх мэдээ, тайлан, тайлбар, тодруулга нь тодорхойгүй, нотлох баримтаар хангагдахгүй байна.
4. Австралийн Комманд Петролеум компаниар толгойлуулсан олон улсын газрын тосны консорциум нь "СОКО Монгол Инк"-д эрхээ шилжүүлсэн тухай болон Соко Тамсаг Монгол ХХК-иас Дачин Ойлфилд Лимитед компанид эрх шилжүүлсэн тохиролцоо нь БХГ-ний 24 дүгээр зүйлд эрх шилжүүлэлтийг МУЗГ-ын бичгээр өгсөн зөвшөөрлийн дагуу олгохоор заасныг зөрчиж байна.
5. Ашигт малтмал, газрын тосны газар /хуучнаар Газрын тосны хэрэг эрхлэх газар/ хуулиар олгогдоогүй эрх эдэлж гэрээлэгчтэй 2004 онд нэмэлт хэлэлцээр хайгуулын хугацааг 5 хүртэл жилээр сунгахаар тохиролцсон нь бүтээгдэхүүн хуваах гэрээтэй нийцэхгүй байна.
6. Мөн гэрээлэгч, Ашигт малтмал, газрын тосны газар /хуучнаар Газрын тосны хэрэг эрхлэх газар/ хооронд 2004 онд байгуулсан түүхий тос тээвэрлэх, борлуулах тухай протоколоор борлуулалтын зардлыг Монголын талаас эргүүлэн авахаар тохирсон нь БХГ-тэй нийцээгүй, уг хэлэлцээр нь хүчин төгөлдөр эрх зүйн баримт бичиг болох нь тодорхойгүй байна.


Энэ нь Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайн талаар байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний 4 дүгээр зүйл, 5 дугаар зүйлийн 5.1, 5.2, 5.4, 5.5, 8 дугаар зүйлийн 8.3-д “Хуанлийн сард ногдох өртөгт тосны нийт хэмжээг хасаад үлдсэн бүх гэрээт түүхий тос (Хуваах тос)-ыг МГТ компани болон гэрээлэгчийн хооронд тухайн хуанлийн сард гаргасан хуваах тосны өдрийн дундаж хэмжээнд тулгуурлан дор заасан харьцаагаар хуваана”, БХГ-ний 2.2-д тодорхойлолтуудад “хуваах тос” гэж олборлосон нийт тосноос төлбөр (Роялти) болон өртөгт тосыг хасаад үлдэх хэсгийг хэлнэ”, “Хүчин төгөлдөр болсон өдөр” гэж МУЗГ-аас энэхүү гэрээг баталсан он сар өдрийг хэлнэ” гэсэн Бүтээгдэхүүн хуваах гэрээ, Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчсөн, уг хэлэлцээрийг баталсан тогтоол шийдвэр гэж заасныг тус тус зөрчиж байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.8, 4.2.1.11-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. БХГ-г үндэслэн үр ашигтай нээлт гэж тооцсон цооног тус бүрийн хугацааг нарийвчлан тогтоож бүртгэлжүүлэх;
2. Тосон Уул XIX талбайн Бүтээгдэхүүн хуваах гэрээний хугацаа дууссан тул уг талбайгаас олборлосон газрын тосны экспортлох үйл ажиллагааг зогсоох;
3. Газрын тосны үйл ажиллагааны явцад гэрээлэгч хариуцах зардлыг үр ашигтай нээлт гэж нөхөж авахаар буруу тооцон 2018 оны жилийн эцсийн байдлаар хуримтлуулсан 2,100.4 сая ам.долларын өртөг зардлыг МУЗГ Бүтээгдэхүүн хуваах нөхцөлөөр нөхөж төлөхгүй байхаар аудитаар баталгаажуулж байгааг гэрээлэгчид мэдэгдэж тооцоо нийлэх;
4. Эрх шилжүүлсэн тохиролцоо, хугацаа сунгасан хэлэлцээр, борлуулалтын зардлыг Монголын талаас эргүүлэн авахаар тохирсон протоколууд нь БХГ-ний адил хүчин төгөлдөр эрх зүйн баримт бичиг болохыг тодорхой болгох;
5. Тохиролцоо, хэлэлцээр, протокол зэрэг БХГ зөрчсөн эрх зүйн баримт бичгийг мөрдөхгүй байх;
6. Цаашид зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Ашигт малтмал, газрын тосны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Л.Баярмандал/-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН НЭГДСЭН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Я.САМБУУНЯМ
Д.ОТГОНБАЯР
Л.НЯМТӨМӨР
Ц.БАТСҮХ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 12 дугаар сарын 15 № 1135/А0170050
Схмт-2023/11-НА-НА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Газрын тосны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2, 37 дугаар зүйлийн 37.2, 37.3-д заасныг үндэслэн газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтыг баталгаажуулах аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Газрын тосны чиглэлээр 2005 оноос хойш үйл ажиллагаа эрхэлж байгаа "Петрочайна Дачин Тамсаг" ХХК нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг мөрдөхгүй, үндсэн үйл ажиллагаатай холбоотой ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд иж бүрэн тусгаагүй байхад Сангийн яам нь холбогдох хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д "Санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ", 17.1.7-д "энэ хуульд заасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт мөрдөх үүрэгтэй аж ахуйн нэгж, байгууллага энэхүү стандартыг хэрхэн мөрдөж байгаад харилцагч санхүүгийн байгууллагатай хамтран хяналт тавих" гэж заасныг зөрчиж байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.8-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Газрын тосны салбарт олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагад санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг мөрдүүлэх, харилцагч санхүүгийн байгууллагатай хамтран хяналтыг хэрэгжүүлж байх, биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байхыг Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Ж.Ганбат/-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН НЭГДСЭН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Я.САМБУУНЯМ
Д.ОТГОНБАЯР
Л.НЯМТӨМӨР
Ц.БАТСҮХ



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР,
ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН ТЭРГҮҮН
ЗӨВЛӨХ Б.ЖАРГАЛСАЙХАН
ТАНАА

2023.12.26 № 2585

танай _____-ны № _____-т

Гэмт хэргийн шинжтэй мэдээлэл
шилжүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2022 оны 09 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны А/04 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3 дэх хэсэгт тодорхойлсон бүрэн эрхийг үндэслэн “Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх” аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Бүтээгдэхүүн хуваах гэрээний 4 дүгээр зүйлд зөвхөн үр ашигтай нээлт хийсэн нөхцөлд гэрээлэгч өртөг зардлыг нөхөж авахаар заасан боловч Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайд үр ашигтай нээлт илрүүлсэн баримт мэдээлэл байхгүй, Засгийн газрын төлөөлөгчид мэдэгдсэн эсэх нь тодорхойгүй байхад 1996-2018 оны хугацаанд 1,181.9 сая ам.долларын өртөг зардлыг нөхөн авч, 2,100.4 сая ам.долларын өртөг зардлыг нөхөж авахаар хуримтлуулан тооцсон байна.
2. Гэрээний талууд хайгуулын хугацааг хэрхэн сунгасан, олборлолтод хэзээ шилжсэн талаарх үндэслэлтэй тайлбар, тодруулга, нотлох баримтыг гаргаж чадахгүй байна. Тосон Уул XIX талбайд Өртөг нөхөгдөх зардлыг анх нөхөж авсан 1996 оноос тооцвол 2016 онд анхны үр ашигтай цооногийн хугацаа дуусаж, үр ашигтай нээлт бүртгэгдэх сүүлийн хугацаагаар тооцвол 2023 оны 4 дүгээр сард Тосон Уул XIX талбайн Бүтээгдэхүүн хуваах гэрээний хугацаа бүрэн дууссан байна. Гэрээний талууд БХГ-ээр тогтоосон хайгуулын хугацааг хэрхэн сунгасан, үр ашигтай нээлтийг хэзээ бүртгүүлсэн талаарх мэдээ, тайлан, тайлбар, тодруулга нь тодорхойгүй, нотлох баримтаар хангагдахгүй байна.
3. Австралийн Комманд Петролеум компаниар толгойлуулсан олон улсын газрын тосны консорциум нь “СОКО Монгол Инк”-д эрхээ шилжүүлсэн тухай болон Соко Тамсаг Монгол ХХК-иас Дачин Ойлфилд Лимитед компанид эрх шилжүүлсэн тохиролцоо нь БХГ-ний 24 дүгээр зүйлд эрх шилжүүлэлтийг МУЗГ-ын бичгээр өгсөн зөвшөөрлийн дагуу олгохоор заасанг хэрэгжүүлж ажиллаагүй нь байгалийн хэвлийд хууль бусаар халдсан байж болзошгүй байна. /Аудитын тайлангийн 24-р хуудас/.
4. Ашигт малтмал, газрын тосны газар /хуучнаар Газрын тосны хэрэг эрхлэх газар/ хуулиар олгогдоогүй эрх эдэлж гэрээлэгчтэй 2004 онд нэмэлт хэлэлцээр хайгуулын хугацааг 5 хүртэл жилээр сунгахаар тохиролцсон нь бүтээгдэхүүн хуваах гэрээтэй нийцэхгүй байна.


5. Мөн гэрээлэгч, Ашигт малтмал, газрын тосны газар /хуучнаар Газрын тосны хэрэг эрхлэх газар/ хооронд 2004 онд байгуулсан түүхий тос тээвэрлэх, борлуулах тухай протоколоор борлуулалтын зардлыг Монголын талаас эргүүлэн авахаар тохирсон нь БХГ-тэй нийцээгүй, уг хэлэлцээр нь хүчин төгөлдөр эрх зүйн баримт бичиг болох нь тодорхойгүй байна.

Энэ нь Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайн талаар байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний 4 дүгээр зүйл, 5 дугаар зүйлийн 5.1, 5.2, 5.4, 5.5, 8 дугаар зүйлийн 8.3-д “Хуанлийн сард ногдох өртөгт тосны нийт хэмжээг хасаад үлдсэн бүх гэрээт түүхий тос (Хуваах тос)-ыг МГТ компани болон гэрээлэгчийн хооронд тухайн хуанлийн сард гаргасан хуваах тосны өдрийн дундаж хэмжээнд тулгуурлан дор заасан харьцаагаар хуваана”, БХГ-ний 2.2-д тодорхойлолтуудад “хуваах тос” гэж олборлосон нийт тосноос төлбөр (Роялти) болон өртөгт тосыг хасаад үлдэх хэсгийг хэлнэ”, “Хүчин төгөлдөр болсон өдөр” гэж МУЗГ-аас энэхүү гэрээг баталсан он сар өдрийг хэлнэ” гэсэн Бүтээгдэхүүн хуваах гэрээ, Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчсөн, уг хэлэлцээрийг баталсан тогтоол шийдвэр гэж заасныг тус тус зөрчиж байна.

АМГТГ нь газрын тосны тухай хууль болон БХГ-нд заасан хяналт хэрэгжүүлэх чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүйгээс гэрээлэгч талд эрх зүйн зохицуулалтаар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх давуу байдал олгосон байна.

Иймд эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, залилах, байгалийн хэвлийд хууль бусаар халдах зэрэг гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй үйлдлүүдийг харьяалал тогтоон шалгуулж, Төрийн аудитын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д заасны дагуу хариу мэдэгдэнэ үү.

Холбогдох нотлох баримт *65* хуудсыг хавсаргав:

A red rectangular official stamp is placed over a handwritten signature in black ink. The signature appears to be 'Д.ЗАНДАНБАТ'. The stamp contains Mongolian text, including 'МОНГОЛ УЛС' (Mongolia) and 'ХУУЛЬ БУСААР' (Unlawful).

Д.ЗАНДАНБАТ